



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ  
АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ**



**УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2008 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ БОЛОН  
2009 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНААР  
БАТЛАГДСАН ХУУЛИУДЫН  
ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот 2009



## **ӨМНӨХ ҮГ**

Монгол Улсын Их Хурлын 2008 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр Ардчилсан намаас нэр дэвшсэн 28 гишүүн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож өөрийн намын бүлгийг хуульд заасны дагуу байгуулсан билээ.

УИХ дахь Ардчилсан намын бүлэг, түүний гишүүд УИХ-ын 2008 оны намрын болон 2009 оны ээлжит бус чуулганаар ажиллаж баталсан хуулиудын талаар Эрхэм гишүүн танд өөрийн сонгогдсон тойрог болон сонгогч иргэдтэй уулзах үеэр гарын дор ашиглах материал болгож энэ товхимлыг бэлтгэн хүргүүлж байна.

Бидний эмхтгэн гаргасан энэхүү товхимол таны ажилд өчүүхэн боловч тус болно гэдэгт бид итгэж байна.

Энэхүү товхимлын талаар ирүүлсэн аливаа санал, шүүмжлэлийг байнга хүлээн авах болно.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!

**УИХ дахь Ардчилсан намын бүлгийн ажлын алба**

## **НЭГ. УИХ-ЫН 2008 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

Улсын Их Хурлын 2008 оны намрын ээлжит чуулганаар 79 хууль, 48 УИХ-ын тогтоол бүгд 127 хууль, УИХ-ын шийдвэрийн төсөл, түүний дотор 2009 оны улсын төсөв, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх болон төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлүүдийг хэлэлцэн баталлаа.

Монгол Улсыг хөгжүүлэх сангаас 30 тэрбум төгрөгийг ямааны ноолуурын үнийн зөрүүд, 40.0 тэрбум төгрөгийг хүнсний буудайн нөөц хэлбэрээр байршуулахад мөн банк, санхүүгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тодорхой дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газраас 180 тэрбум төгрөгийн бонд гаргаж арилжаалах боломжийг олгосон билээ.

Түүнчлэн малын хулгайтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх үүднээс холбогдох хууль тогтоомжид зарим өөрчлөлт оруулж, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор банкуудад байршиж байгаа иргэдийн мөнгөн хадгаламжид төрөөс баталгаа гаргаж эрх зүйн үндсийг баталгаажууллаа.

Стратегийн ач холбогдол бүхий орд газрыг ашиглахтай холбогдсон шийдвэр, төрийн захиргааны байгууллагуудын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч, УИХ-аас байгуулагддаг төрийн байгууллагуудын албан хаагчдын ангилал, зэрэглэлийг тогтоож, 5 дугаар сарын сүүлчээр Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулахаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулав.

2008 оны 9-р сарын 01-д байгуулагдсан УИХ дахь Ардчилсан намын бүлэг 36 удаа хуралдаж 76 асуудал хэлэлцэн, шаардлагатай гэж үзсэн 9 хуулийн төсөлд санал дүгнэлт гаргаж нэгдсэн чуулган болон холбогдох байнгын хороодод хүргүүлжээ.

Бүлгээс намрын чуулганаар хэлэлцэж байгаа асуудлаар нийт 16 ажлын хэсэг байгуулан ажилласнаас гадна УИХ-аар хэлэлцэж буй асуудлыг хэлэлцэх ажилд сайжруулах үүднээс

- Улс төр, аюулгүй байдал
- Санхүү, эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого
- Үйлдвэржилт, байгаль орчин, экологи
- Хүний эрх, хууль, эрх зүй
- Нийгмийн бодлого, хүний хөгжил зэрэг үндсэн 5 чиглэлээр байнгын ажлын хэсгүүдийг байгуулан ажиллаж байна.

УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд энэ чуулганы хугацаанд нийт 23 хуулийн төсөл санаачилсан байна.

## **МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2009 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

УИХ-ын 2008 оны ээлжит сонгуульд оролцсон улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр, МАХН, АН-ын хамтран ажиллах гэрээ, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, салбаруудын хөгжлийн хөтөлбөр, үзэл баримтлал зэрэг бодлогын баримт бичгүүдэд үндэслэн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг боловсруулсан.

Дэлхий даяар санхүүгийн хямрал болж буй энэ цаг үед Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлагдан гарч байгаагаар өмнөх онуудын үндсэн чиглэлээс онцлогтой болсон гэж үзэж байна. 2009 оны Үндсэн чиглэлийн гол онцлог нь Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан, манай улсын эрчимтэй хөгжлийн гарааны үе шаттай уялдан, эдийн засгийн салбаруудыг өргөжүүлж өсөлтийг нэмэгдүүлэх, энэ онд бий болсон өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын өндөр өсөлтийг саармагжуулж бууруулах, нийгмийн чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг тогтвортой үргэлжлүүлэхэд чиглэгдсэнээр онцлогтой болжээ.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл нь 6 бүлэг 21 зорилттой бөгөөд дараах үндсэн зорилтуудыг хэрэгжүүлнэ.

### **1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

Энэ бодлогын хүрээнд 2 зорилт бүхий 21 хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөсөн байна.

Эдийн засгийн салбаруудын үйл ажиллагааг өргөжүүлэх замаар түүний өсөлтийг нэмэгдүүлж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулахад чиглэсэн бодлогыг 2009 онд хэрэгжүүлэх юм. ДНБ-ий бодит өсөлтийг 10.1 хувьд байлгах аар, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээг 2042.1 ам доллар болгохоор төлөвлөж байна.

Төсөв, мөнгөний харилцан уялдаа бүхий бодлогыг хэрэгжүүлэн, үнэ тарифын харьцангуй тогтвортой байдлыг хангаж, инфляцийг нэг оронтой тоонд байлгана.

Төсвийн орлого, зарлагын харьцааг зохистой түвшинд байлгаж, хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийг үе шаттайгаар хэрэгжүүлэн ДНБ-д нэгдсэн төсвийн орлогын эзлэх хэмжээг 34.3, зарлагын хэмжээг 40.4 хувьд, урсгал төсвийн ашгийн эзлэх хэмжээг 4.6 хувьд байлгах аар төлөвлөж байна. Харин ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хэмжээ -6.1 хувьд байхаар тооцож байна.

Ирэх онд мөнгө, сангийн болон бодит эдийн засгийн бодлогын хоорондын уялдааг хангах зохицуулахтай холбогдуулан эрх зүйн орчны шинэтгэлийг хийж, хэрэгжүүлнэ. Мөн банкны салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэн, монополи байдлыг арилгаж төрөөс олгож буй цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг иргэдэд хүргэх үйлчилгээг арилжааны банкуудын дунд тендер зарлаж сонгон шалгаруулах зарчмыг хэрэгжүүлэх юм. Түүнчлэн банк санхүүгийн системийн тогтвортой үйл ажиллагааг хангах, эдийн засгийн өсөлт, бодит салбарын хөгжлийн дэмжсэн бодлогыг Төв банктай хамтран хэрэгжүүлж энэ хүрээнд 3 тэрбум ам долларын хөрөнгийг төлөвлөөд байна.

Төсвийн зарцуулалтад хяналт тавих асуудал өнөөдрийн тулгамдаж буй асуудлуудын нэг болоод байна. Төсвийн зарлагад хяналт тавих зөв механизм бол хөндлөнгийн болон дотоод аудитын үйл ажиллагаа гэж үзэж ирэх онд уг үйл ажиллагааг боловсронгуй болгон нэвтрүүлэхээр тогтоолд тусгалаа.

## **2. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

Энэ бодлогын хүрээнд 7 зорилт бүхий 88 хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөжээ. Хувийн хэвшил бизнесийн хөгжлийг дэмжсэн төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, байгаль экологит ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зорилтыг 2009 оны Үндсэн чиглэлд дэвшүүллээ.

Энэ зорилтын хүрээнд төр болон хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулан тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоог боловсронгуй болгож хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдсан объектуудыг тодорхой хугацаагаар ашиглуулсны дараа төрд шилжүүлж өгөх ажиллагааг дэмжих зорилт дэвшүүллээ.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, ядуурлыг бууруулахад нөлөө үзүүлэх стратегийн томоохон орд, газруудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах бэлтгэлийг хангах арга хэмжээ авна. Үүнд:

Оюу толгойн зэс, алтны уурхайг барьж эхлэх, Таван толгойн нүүрсийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх,

Баянгол, Төмөртэйн төмрийн хүдрийн ордыг ашиглах, Шинэ үйлдвэржилтийн бодлогыг хэрэгжүүлж эхлэх, бүсийн тулгуур төвүүд болон зарим орон нутагт үйлдвэр-технологийн парк, технологи дамжуулах төв байгуулах, тэргүүний технологийг нэвтрүүлэх,

Дотооддоо газрын тос боловсруулах үйлдвэр барьж байгуулах талаар судалж, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, барьж эхлэх, Улаанбаатар хотод дулаан, цахилгааны 5 дугаар станцыг шинээр барих ажлыг эхлүүлэх; Нүүрс, шатдаг занар, биомасс зэрэг түүхий эдээс шингэн түлш гарган авах технологийг турших ажлыг эхлэх зэрэг асуудлуудыг 2009 оны Үндсэн чиглэлд тусгалаа

Боловсруулах үйлдвэрлэлийн “Монгол брэнд”-ийг бий болгож, ноолуур, арьс, ширэн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүн болгох үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хонь болон тэмээний ноос зэрэг түүхий эдийн үнийг өсгөх арга хэмжээ авна. Аймаг, нийслэлд “Жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх сан”-г байгуулж жижиг, дунд бизнесийг дэмжих мөн үйлдвэржилт, жижиг, дунд үйлдвэрлэл болон ажил эрхлэлтийг дэмжихэд зориулж улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сан, гадаадын зээл тусламж, хувь хүний орлогын албан татварын орлого зэрэг эх үүсвэрүүдээс 150 тэрбумаас доошгүй төгрөгийн хөрөнгө гаргах ажлыг эхлүүлэх. бодлого баримтлах юм.

Хүн амыг эрүүл хүнсээр хангах зорилгоор мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг нэмэгдүүлж, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангах зорилтыг ирэх онд авч хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд 4 сумын төв болон 8000 малчин өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангах зорилтыг ирэх онд дэвшүүлсэн. Мөн тариалан эрхлэгч компани болон малчдад 3000 бага оврын трактор, хөрс боловсруулах техник хэрэгсэлийг хөнгөлттэй үнээр нийлүүлэх юм.

Хүнс, хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнийг борлуулах биржийн сүлжээ бий болгох, өрхийн аж ахуйгаас бэлтгэсэн илүүдэл хүнсний ногоо, сүү, цагаан идээ, махыг борлуулахад зориулж татвар, түрээсийн төлбөргүй хүнсний зах, салбар, цэгүүдийг аймаг, сумын төв, нийслэлийн дүүрэг, хороодод байгуулан ажиллуулж эхэлнэ.

Газар тариалангийн салбарт “Атрын 3 дахь аян”-ы хэрэгжилтийг эрчимжүүлж, газар тариалангын үйлдвэрлэлийн техник тоног төхөөрөмжийг шинэчлэх, дотоодын үйлдвэрлэлийн улаан буудай, төмс хүнсний ногооний хангамжыг дээшлүүлэх. Ингэснээр гурилынхаа хэрэгцээний 60.0-аас доошгүй хувийг дотоодын улаанбуудайгаар хангана.

Мөн дээрх ажлын хүрээнд “Чацаргана” төслийг боловсруулж хэрэгжүүлэх, энэ төслийн хүрээнд улсын хэмжээнд эхний ээлжинд 20 мянган гектар талбайд чацаргана тариалж,

боловсруулах үйлдвэрүүдийг барих ажлыг эхлүүлнэ. Түүнчлэн 2009 онд мэргэжилтэй малчин бэлтгэхэд төрөөс анхаарч ажиллах юм.

Хот болон аймгийн төвийн гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах төсөл боловсруулж гэр хорооллын доторхи зам, цэвэр усны шугам, гэрэлтүүлэг зэрэг дэд бүтцийг шийдвэрлэж эхлэх юм. Улсын чанартай болон хот хоорондын гол зам дагуу 100-150 км тутамд үйлчилгээний тохилог цогцолбор барих хөтөлбөр, төслийн техник эдийн засгийн үндэслэл, судалгаа, зураг төслийг боловсруулж, хөтөлбөр төслийг эхлүүлнэ. Төмөр замын хос шугам барих асуудлыг судалж ажил хэрэг болгоно.

Дунд хугацаанд барилгын салбар нилээд хурдацтай хөгжихийн хэрээр барилгын материалын хомсдол бий болж үнэ хэт хөөрөгдөх явдал гарч болзошгүй байгаа тул 2009 онд орон нутгийн эрдэс, түүхий эдийн нөөцөд тулгуурлан барилгын материалын үйлдвэрийг хөгжүүлэхээр Үндсэн чиглэлд тусгалаа.

### **3. БҮС НУТАГ, БАЙГАЛЬ ОРЧИН ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

Энэ бодлогын хүрээнд 3 зорилт бүхий 34 хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөсөн байна.

Байгалийн нөөц баялгийн менежментийн эрхзүйн хэрэгжилтийг гүнзгийрүүлж, байгаль орчныг хамгаалахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, агаар, ус, хөрсний бохирдол, орчны доройтлыг бууруулах, хянах тогтолцоог боловсронгуй болгоно.

Байгалийн нөөц баялгийг тогтвортой ашиглах, хүрээлэн буй орчныг нөхөн сэргээх, хамгаалах урт хугацааны бодлого боловсруулж хэрэгжүүлэх, байгаль орчинд халгүй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжинэ. Ойжуулалт, мод үржүүлгийн ажлын чанарыг дээшлүүлэх, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх ажилд ард иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. Энэ хүрээнд 2009 онд ойжуулалтын хэмжээг 12 мянган га-д, үрийн нөөцийг 300 кг, тарьц, суулгац 5 мянга, ой зохион байгуулалтын ажлыг 19 мянган га-д хийхээр төлөвлөв.

Мөн бүсүүдийн тулгуур төв болон хот, суурин газрын усан хангамжийн эх үүсвэрийн эрэл хайгуул, судалгааны ажлыг явуулж, нөөцийн хэмжээг тогтоох, ан амьтны тархац, нөөцийг тогтоож, хамгаалах менежментийг боловсронгуй болгоход иргэд, аж ахуйн нэгжийн ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх санаачлагыг дэмжинэ. Биологийн төрөл зүйлийг хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлэх үйл ажиллагаанд ард иргэдийг өргөн оролцуулсан хамтын менежментийг боловсронгуй болгох чиглэлээр ажиллана. Хяналт шинжилгээ, судалгааны нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар үнэлгээ хийх шинжилгээний лабораторитой болно.

Говь, хээрийн цөлжилт ихээр явагдаж буй бүсүүдэд баянбүрд үүсгэх, худаг ус гаргах, усжуулах санаачлалгыг дэмжиж “Ус” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, хөдөөгийн баг бүрт сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан 1 худаг нэмж гаргах ажил ирэх оноос эхлэн хэрэгжиж эхлэх юм.

Алтны бага нөөцтэй шороон орд, усны хагалбар, голын ай сав газар, ойн сан, баянбүрд, байгалийн онцгой тогтоц бүхий газрууд, түүний хамгаалалтын бүсэд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон байдлыг үе шаттайгаар зогсоож, байгаль орчин, хүний эрүүл мэндэд халтай технологиор уул уурхайн үйлдвэрлэл явуулахыг хориглох юм. Улаанбаатар хотыг шинэчлэн хөгжүүлэх “Шинэ Улаанбаатар-Ногоон нийслэл” хөтөлбөр батлах, нийслэлд агаар болон хөрсний бохирдлыг бууруулах, дэд бүтэц, хогны асуудлыг иж бүрэн шийдвэрлэх, хот байгуулалт, хот төлөвлөлтийн бодлогыг шинэчлэн баталж, хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэнг дүүрэг бүрт байгуулж эхлэх зорилт дэвшүүлээд байна.

#### **4. ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ БОДЛОГО**

Энэ бодлогын хүрээнд 3 зорилт бүхий 63 хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөжээ. Ирэх онд хүн амын өсөлтийг дэмжих хүрээнд хүүхдийн мөнгө, шинэ гэр бүл, шинэ хүүхэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх юм.

Стратегийн болон томоохон орд газруудаас олсон орлогоос иргэдэд хувь хүртээх эрх зүйн орчин болон санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэн хэрэгжүүлнэ.

Ерөнхий боловсролын сургалтыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлж эхэлсэнтэй холбогдуулан бүх шатны боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэх томоохон зорилтыг дэвшүүлж байна. Энэ зорилтын хүрээнд сургуулийн өмнөх боловсролын сургалтын агуулга, хөтөлбөрийг сайжруулж, сургуулийн өмнөх насны хамран сургалтын түвшинг 2009 онд 60 хувьд хүргэх, Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн “Үдийн цай” болон “Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зэрэг олон асуудлуудыг шийдвэрлэнэ. Засгийн газраас жил бүр шаардлагатай мэргэжлийн жагсаалт, ангилал, тоог зарлаж сургалтын төрийн сангаас үзүүлж буй зээл тусламжийг тодорхой шалгуур хангасан суралцагчдад олгодог байхаар холбогдох журмыг өөрчлөх, ерөнхий боловсролын сургуульд түүх соёлоо дээдлэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх юм.

Соёлын өв уламжлалыг хадгалан хөгжүүлэх ажлын хүрээнд соёлын тухай хуулийг боловсронгуй болгож, “Монгол Улсын соёл, урлагийг 2009-2021 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г батлуулж, хэрэгжүүлж эхлэх, Үндэсний уламжлалт соёлын өвөө хадгалж хамгаалах, сэргээн засварлах ажлыг нэмэгдүүлнэ. Сумын соёлын төвийн үйл ажиллагааны агуулга, хэлбэрийг баяжуулж тогтмолжуулах, соёлын төвүүдийн барилгыг шинэчилж, засварлах, хөгжмийн зэмсэг, ном, тоног төхөөрөмжөөр хангах замаар хүүхэд, залуус, хүн амд хүргэх соёлын үйлчилгээний нийгмийн үр өгөөжийг дээшлүүлэх зэрэг зорилт, арга хэмжээг 2009 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Шинжлэх ухаан, технологи, инновацийн талаар төрөөс баримтлах бодлогыг шинэчлэн тодорхойлж, технологийн хөгжлийн чиг хандлагыг үйлдвэрлэлтэй уялдуулан хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилтэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж биотехнологи, нанотехнологи зэрэг дэвшилтэт технологийн судалгаа боловсруулалт, туршилт-сорилтын баазыг бэхжүүлнэ. Түүнчлэн шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлээр нарийн мэргэшсэн эрдэм шинжилгээний ажилтан, залуу судлаачдыг дотоод, гадаадад бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх чиглэлээр ажиллана.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амд тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлж элдэв өвчлөлийг эрс бууруулж, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, хүн амын өсөлтийг дэмжих зорилтыг 2009 онд дэвшүүлж байна.

Энэ зорилтын хүрээнд хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг шинэчилж, Монгол Улсын нутаг дэвсгэрийн алслагдсан аль ч газарт шаардлагатай үед цаг алдалгүй хүрч тусламж үзүүлэх “Үндэсний түргэн тусламжийн сүлжээ” байгуулах, эрүүл мэндийн үйлчилгээнд орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололтуудыг нэвтрүүлж, улсын хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зайны оношилгооны цахим эмнэлгийн нэгдсэн сүлжээг бий болгох, малчин, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг нөхөн үржихүйн эм, хэрэгслээр тогтвортой хангах ажлыг үе шаттайгаар эхлүүлэх зэрэг зорилтуудыг хангаж ажиллахаар төлөвлөсөн.

Малчин бүрийг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалтай болгох ажлыг эхлүүлнэ. Эрүүл мэндийн үйлчилгээнд эрхийн бичгийн тогтолцоог нэвтрүүлж, иргэн бүрийг жилд нэг

удаа эмнэлгийн иж бүрэн, нарийн мэргэжлийн цогц үзлэг оношлогоонд хамруулах ажлыг зохион байгуулж эхлүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлж өвчлөлийг эрс бууруулж, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, хүн амын өсөлтийг дэмжихэд чиглүүлэх зорилтыг Үндсэн чиглэлд дэвшүүллээ.

## **5. ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО**

Энэ бодогын хүрээнд 5 зорилт бүхий 38 хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөсөн.

Нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогын хүрээнд улс орнуудтай найрсгаар харилцаж, харилцан ашигтай хамтын ажиллагаа өргөжүүлж, хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэсэн орчныг бүрдүүлэх үйл ажиллагаа явуулна. Энэ зорилтийг хэрэгжүүлэх хүрээнд гадаад орнуудын улс төр, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодит сонирхлыг Монгол Улсад бий болгохдоо үндэсний аюулгүй байдал, ард түмний язгуур эрх ашгийн үүднээс зохистой тэнцвэрийг хадгалах бодлого явуулна. Европын чөлөөт худалдааны нийгэмлэгтэй байгуулсан хамтын ажиллагааны тунхаглалаа хэрэгжүүлэх, ДХБ-ын ДОХА-гын шатны гэрээ хэлэлцээр, НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, далайд гарцгүй, эмзэг эдийн засагтай орнуудад үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээ, хүрээг тогтоож нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг 2009 оны Үндсэн чиглэлд тусгалаа.

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бэхжүүлэн, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах, цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд идэвхитэй оролцож, Зэвсэгт хүчний шинэчлэлийн бодлогыг эрчимтэй хэрэгжүүлнэ. НҮБ-ын мандатын дор явагдаж байгаа энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний бүрэлдэхүүний оролцох оролцоог нэмэгдүүлэх, дайчилгааны хуулийн дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн 1, 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтний, төрийн болон орон нутгийн удирдах бүрэлдэхүүний цэрэг-стратегийн, цэргийн бэлтгэл сургалтуудыг зохион байгуулах, экологийн сүйрлээс сэрэмжлэн хамгаалах, ойжуулах, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх зэрэг ажил үүрэг биелүүлэхэд цэргийн дүйцүүлэх албаны оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллана.

Ирэх онд “Зэвсэгт хүчний хөгжил сан”-г байгуулан зэвсэгт хүчний цаашдын хөгжлийг хангах эдийн засгийн үндсийг бүрдүүлэх юм. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг орон нутагт бэлтгэх тогтолцоог төгөлдөржүүлж, бүсийн сургалтын төвүүдийг үе шаттайгаар байгуулах, Монгол Улсын хил хамгаалалтад орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, хил хамгаалалтын нэгдмэл тогтолцоог баталгаажуулна.

Мөн мэргэжлийн хяналтын байгууллагын лабораторын хүчин чадлыг нэмэгдүүлж, баталгаажилтын түвшинг дээшлүүлэн, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөр эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэх, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг боловсронгуй болгож, учрах хохирлын хэмжээг багасгах чиглэлээр идэвхитэй ажиллана.

## **6. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН БОДЛОГО**

Энэ бодлогын хүрээнд 1 зорилт бүхий 14 хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөжээ.

Иргэдээ идэвхжүүлж, иргэний нийгмийг төлөвшүүлэх нь ардчилсан нийгмийн төгөлдөршилтийн нэг гол шалгуур тул төр-иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлж, иргэний нийгмийг оролцоог хангана. Энэ хүрээнд хууль тогтоомж хоорондын зөрчлийг арилгах, уялдаа холбоог сайжруулах, иргэн, аж ахуйн чиглэлийн хууль, тогтоомжийг харьцуулан судалж, давхардал, хийдлийг тогтоох ажлыг эхлүүлэх, иргэний нийгмийн байгууллагаас төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих эрхийг нь холбогдох хууль тогтоомжид тусган хэрэгжүүлэх, нийгэмд тулгамдсан зарим зорилтыг

шийдвэрлэхэд иргэний нийгмийн байгууллагуудтай зөвшилцөх арга хэлбэрийг бий болгох, нийгмийн зохион байгуулалт, эмх цэгц, сахилга, дэг журмыг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн амь нас, аюулгүй байдлыг хангах, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын цар хүрээ, чанар, үр нөлөөг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Мөн нийтийн эрх ашгийг хөндсөн томоохон хуулиудыг Улсын Их Хурлаар батлахаас 45-аас доошгүй хоногийн өмнө иргэд, олон нийтээр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж санал авдаг журмыг хэвшүүлнэ.

Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл нь 2008-2012 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх гарааны жилд хэрэгжих онцлог ач холбогдолтой бөгөөд энэ утгаараа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудын 80 орчим хувь нь ирэх оны үндсэн чиглэлд тусгагдсан юм.

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2008-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, 2008 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцсон МАХН болон Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөр, эдгээр намуудын Улсын Их Хурлын сонгуулийн дараа байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, бусад намуудын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн зарим зорилт, төрийн бус байгууллагын санал, олон улсын байгууллагатай хийсэн баримт бичгүүдийг үндэслэн 2008-2012 онуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө тодорхойлж байна.

Өмнөх Засгийн газар нь нийгмийн томоохон зорилтуудыг хэрэгжүүлэх, төрийн албыг чадваржуулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай болгох, хувийн хэвшлийг дэмжих, эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, хөгжлийг бататгах зэрэг тулгамдсан олон асуудлыг шийдэж, цааш үргэлжлүүлэн хийж бүтээх суурийг нь тавьж өгсөн юм. Шинэ Засгийн газар өмнөх Засгийн газруудын үйл ажиллагааны залгамж чанарыг хадгалж, 2008-2012 оны үйл ажиллагааныхаа чиглэлд тусгасан болно.

Дэлхийн санхүүгийн хямралын улмаас Монгол Улсын эдийн засаг, санхүүд нөлөөлж буй хүндрэлийг даван туулах онцгой нөхцөлд Засгийн газрын зорилт нь эрдэс түүхий эдийн нөөцөд тулгуурлан улс орныхоо эдийн засаг, нийгмийн хурдацтай хөгжлийн боломжийг цаг алдалгүй бүрэн ашиглахыг чармайж, Монгол Улс, монгол хүний хөгжлийг хангахуйц чадавхи бүрдүүлэн иргэдийнхээ аж амьдралыг эрс сайжруулж, төрийн удирдлагын ил тод, нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй байдлыг хангаж, бүх шатны төр, засгийн байгууллагын нэр хүндийг дээшлүүлж, нийгмийн итгэлцлийг бэхжүүлэн, улс үндэстний аюулгүй байдлыг баталгаажуулахад оршино.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний биелэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан УИХ-д Засгийн газраас танилцуулах, мөн хөтөлбөрт туссан зорилтуудыг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгах, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай нягт уялдуулан ажиллахыг Монголбанкны

Ерөнхийлөгч, УИХ-д ажлаа шууд тайлагнадаг холбогдох бусад байгууллагын дарга нарт үүрэг болгохыг УИХ-аас тогтоосон. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь 5 бүлэг, 19 зорилттой.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь дараахь үндсэн зорилтыг хэрэгжүүлнэ:

- ашигт малтмалын салбарын хөгжлийг түргэтгэж эрх зүйн орчныг шинэчлэх, ашигт малтмалын стратегийн болон томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг бодитойгоор хэрэгжүүлж, түүнээс олсон орлогоос
- иргэдэд хүртээх;
- Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, уул уурхайн салбарт түшиглэсэн үйлдвэрлэл, орон нутгийн түүхий эдэд тулгуурласан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүнээр, тухайлбал, мах, сүү, гурил, төмс, хүнсний ногоогоор хүн амын хүнсний хэрэгцээг бүрэн хангах;
- иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд онцгой анхаарах;
- төрийн удирдлагын ил тод, нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх,

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2008 2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ  
АРДЧИЛСАН НАМААС УИХ-ЫН СОНГУУЛЬД ДЭВШҮҮЛСЭН МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОН  
УИХ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ, ГИШҮҮДИЙН ГАРГАСАН САНАЛААС ТУСГАСАН  
БАЙДАЛ**

|                                                                                   |                                                                    |                                                               |
|-----------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------|
| <b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2008<br/>2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ<br/>ХӨТӨЛБӨР</b> | <b>АН-н 2008 оны сонгуульд<br/>оролцсон мөрийн<br/>хөтөлбөрөөс</b> | <b>УИХ дахь АН-н<br/>бүлэг,<br/>гишүүдээс<br/>орсон санал</b> |
|-----------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------|

**Нэг. Хүн ам, нийгмийн зохистой бодлогыг хэрэгжүүлснээр иргэдийн амьдралын чанарыг  
сайжруулах зорилт**

**1.1. Эрүүл мэндийн бодлого**

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                 |            |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|
| 1.1.3. Эрүүл мэндийн үйлчилгээнд эрхийн бичгийн тогтолцоог нэвтрүүлэн урьдчилан сэргийлэх зарчмыг баримталж, иргэн бүрийг жилд нэг удаа эмнэлгийн иж бүрэн, нарийн мэргэжлийн цогц үзлэг оношилгоонд хамруулна.                                                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                 | АН-н бүлэг |
| 1.1.4. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үнэ төлбөргүй авах эрхийн бичиг олгоно.                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                 | АН-н бүлэг |
| 1.1.5. Эрүүл мэндийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төрийн оролцоог багасгах зорилгоор хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад хувийн хэвшлийн мэргэжлийн эмнэлгийн оролцоог дэмжинэ. Энэ зорилтын хүрээнд эрүүл мэндийн салбарын санхүүжилтэд хувийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, өмчийн хэлбэрийг үл харгалзан эмнэлгүүдийг даатгалын үйлчилгээнд жигд хамруулна. | Эрүүл мэнд дэх төрийн оролцоог даатгалын үйлчилгээгээр солих бодлогыг шат дараатай хэрэгжүүлнэ. Эрүүл мэндийн даатгалыг гэр бүлийн даатгалын тогтолцоонд шилжүүлж, даатгалын олон төрөл хэлбэрийг дэмжинэ.                      | АН-н бүлэг |
| 1.1.10. Говийн бүс болон Орхон аймагт орчин үеийн эмчилгээ, оношилгооны төвийг байгуулна.                                                                                                                                                                                                                                                                                                                          | Шинжлэх ухааны сүүлчийн ололтод тулгуурласан эмнэлгийн нарийн мэргэжлийн оношлогоо шинжилгээ, эмчилгээ үйлчилгээний төвүүдийг байгуулахыг дэмжинэ.                                                                              |            |
| 1.1.11. Хүн амын эрүүл мэндийн мэдээллийн цахим сан байгуулна. Эмнэлгийн цахим сүлжээ, алсын зайн оношилгоо, эмчилгээг өргөжүүлэн, иргэн бүрт эрүүл мэндийн үйлчилгээг шаардлагатай түвшинд үзүүлэх бололцоог хангах зорилгоор анагаах ухааны орчин үеийн ололтод тулгуурласан төрөлжсөн мэргэжлийн төвүүдийг хөгжүүлж, өвчнийг эрт оношлох, эмчлэн, нөхөн сэргээх чадавхийг дээшлүүлнэ.                           | Багш эмч нарт зориулсан мэргэжлийн улсын хэмжээний онлайн сүлжээг төрөөс дэмжиж, мэдээллийн технологи, зайнаас сургалт, оношлогоо, эмчилгээ хийх дэвшилтэт тоног төхөөрөмж ашиглах суурь чадвар эзэмшүүлнэ.                     | Д.Одхүү    |
| 1.1.17. Эмч, эмнэлгийн ажилтны мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлж, ёс зүй, хариуцлагыг өндөржүүлнэ.                                                                                                                                                                                                                                                                                                          | Иймээс энэ салбарт ажиллагсадын мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх, нийгмийн үнэлэмжийг өсгөхөд онцгой анхаарна.                                                                                                                   |            |
| 1.1.21. Нийслэлийн дүүрэг бүрт усан бассейн бүхий орчин үеийн спортын цогцолбор барина.                                                                                                                                                                                                                                                                                                                            | Усан бассейн, спорт тоглоомын заал бүхий бүрэн тоноглогдсон биеийн тамир, спортын цогцолборыг нийслэлийн дүүрэг, аймгийн төвүүдэд барьж байгуулна. Нийтийн биеийн тамир, спортын ояныг хамарсан арга хэмжээг бодлогоор дэмжинэ. | АН-н бүлэг |
| 1.1.22. Улаанбаатарт телемедициний төв                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                 | З.Энхболд  |

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                                                                                          |            |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|
| байгуулна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                          |            |
| <b>1.2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны бодлого</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                          |            |
| 1.2.6.Төрөөс ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг сурах бичгээр хангана.                                                                                                                                                                                                                                                                                                                   | Бүх шатны сургуульд иргэний боловсрол олгох сургалтыг дэмжинэ. Дунд сургуулийн зайлшгүй шаардлагатай сурах бичгүүдийн стандарт, чанарыг жигдэлж хэвлэлтийн зардлыг төрөөс хариуцна.                                                                                      |            |
| 1.2.8.Ерөнхий боловсролын сургуулийн компьютерийн тоог нэмэгдүүлж, багш бүрийг зөөврийн компьютертай болгоно.                                                                                                                                                                                                                                                                                  | Багш, эмч, сургуулийн сурагчдыг компьютерээр хангах бодлого хэрэгжүүлж сургууль, эмнэлгийн интернетийн үйлчилгээний зардлыг төрөөс даана.                                                                                                                                | АН-н бүлэг |
| 1.2.10.Аймгийн төвүүдэд усан бассейн байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын хичээлийн хөтөлбөрт усанд сэлэлтийн төрлийг оруулна.                                                                                                                                                                                                                                              | Усан бассейн, спорт тоглоомын заал бүхий бүрэн тоноглогдсон биеийн тамир, спортын цогцолборыг нийслэлийн дүүрэг, аймгийн төвүүдэд барьж байгуулна. Нийтийн биеийн тамир, спортын олныг хамарсан арга хэмжээг бодлогоор дэмжинэ.                                          | АН-н бүлэг |
| 1.2.11.Математик болон байгалийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай сургуулийг аймаг, дүүрэг бүрт нэгийг алсын зайн сургалтыг ашиглан зохион байгуулж ажиллуулна                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                          | 3.Энхболд  |
| 1.2.14.Инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, эмч, хөдөө аж ахуйн мэргэжлээр суралцагчдын хувийн жинг нэмэгдүүлнэ. Сургалтын төрийн сангаас үзүүлж буй зээл, тусламжийг Засгийн газраас тогтоосон мэргэжлийн чиглэл, сурлагын амжилтыг дэмжих, алслагдмал нутгийг хэрэгцээтэй мэргэжилтнээр, түүний дотор багш, инженер, техникийн ажилтан, хүний болон малын эмчээр хангахад чиглүүлнэ. | - Ажил олгогчийн захиалгаар суралцагчдыг дэмжинэ. Жил бүр дотоодын болон гадаадын их дээд сургуулиудад 1000-5000 оюутныг нэн шаардлагатай мэргэжлээр сургах “20 жилийн хөтөлбөр” гаргаж төрөөс санхүүжүүлнэ. Шаардлагатай мэргэжлийн жагсаалтыг Засгийн газраас зарлана. |            |
| 1.2.16.Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх бодлого баримтална. Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн сургалтын бааз, лабораторийг сайжруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, оюутны дотуур байрын хүрэлцээг сайжруулна. Геологи, уул уурхайн чиглэлийн дээд болон мэргэжлийн боловсролын сургуулийн хотхоныг Эрдэнэт хотод хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр байгуулна.                  | Эмнэлэг боловсролын төрөлжсөн цогцолбор, <b>оюутны нэгдсэн хотхон байгуулахыг дэмжинэ.</b> Их тэнгэрийн амыг Монголын шинжлэх ухаан, өндөр технологи, чанартай боловсролын нээлттэй бүс болгож хөгжүүлнэ.                                                                |            |
| <b>1.3. Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн бодлого</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                          |            |
| 1.3.6.Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг өрхийн хэрэгцээтэй уялдуулж, өрхийн нэгээс доошгүй хүнийг ажилтай болгох замаар жилд 60,0 мянгаас дээш ажлын байр бий болгоно.                                                                                                                                                                                                                              | Айл өрх нэг бүрээс доод тал нь ажилгүй байгаа нэг хүнийг мэргэшүүлж ажилтай болгоно                                                                                                                                                                                      |            |
| <b>1.4. Нийгмийн хамгааллын бодлого</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                          |            |
| 1.4.4.Шинээр гэр бүл бологсад, нийт болон шинэ төрсөн хүүхдэд мөнгөн тусламж, тэтгэмжийг үргэлжлүүлэн олгоно.                                                                                                                                                                                                                                                                                  | - Хүүхдийн мөнгийг үргэлжлүүлэн олгоно. Мөнгөний ханш уналттай уялдуулж хэмжээг нь өсгөнө.                                                                                                                                                                               |            |
| 1.4.17.Малчин бүрийг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулна.                                                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                          | АН-н бүлэг |
| <b>1.5. Хүн амын бодлого</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                          |            |
| 1.5.12.Жендэрийн тэгш байдлыг хангах асуудлаар хуулийн төсөл боловсруулан, үндэсний тогтолцоо, хүний нөөц, чадавхийг бэхжүүлэн,                                                                                                                                                                                                                                                                | Төр, нийгмийн бүх салбарт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлж, охид эмэгтэйчүүдийн                                                                                                                                                                                        |            |

|                                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                         |                           |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------|
| жендэрийн статистик мэдээллийг гаргадаг болно.                                                                                                                                                                                                               | эсрэг хүчирхийллийг үл тэвчдэг соёлыг хэвшүүлнэ.                                                                                                                                                                                                                                                                        |                           |
| <b>Хоёр. Үйлдвэржүүлэлтийн бодлого хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангах зорилт:</b>                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                         |                           |
| <b>2.1 Макро эдийн засаг, санхүүгийн бодлого</b>                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                         |                           |
| 2.1.4.Дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгдсэн төсвийн зарлагын эзлэх хэмжээг жил бүр бууруулах бодлого хэрэгжүүлнэ.                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                         | АН-н бүлэг                |
| 2.1.10.Экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн хөгжлийн таатай орчин бүрдүүлэх, экспортын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд татварын болон урамшууллын бодлогоор дэмжлэг үзүүлнэ.                             | Хориглосноос бусад үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай техник тоног төхөөрөмжийг импортын татвараас бүрэн чөлөөлнө.                                                                                                                                                                                                  |                           |
| 2.1.31.Хөгжлийн банк байгуулна.                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                         | Д.Зоригт.<br>Ц.Баярсайхан |
| <b>2.2.Үйлдвэржүүлэх бодлого</b>                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                         |                           |
| 2.2.3.Стратегийн болон бусад томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, Таван толгойн нүүрсний, Оюу толгойн зэс-алтны, Төмөртэйн төмрийн хүдрийн, Цагаан суваргын зэс-молибдений, Асгатын мөнгө-холимог металлын зэрэг ордуудыг ашиглаж эхэлнэ.   | Стратегийн ордуудын 50-иас доошгүй хувийн ашиглалтыг ойрын жилүүдэд түүний дотор Таван толгой, Оюу толгой, Төмөртэйн ордын ашиглалтыг нэн даруй эхлүүлнэ                                                                                                                                                                |                           |
| 2.2.5.Боловсруулах үйлдвэрийн монгол брэндийг бий болгож, ноолуур, <b>хонь, тэмээний ноос</b> , арьс, ширэн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүн болгох үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.                                        | Мал, малын гаралтай болон ХАА-н бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн сүлжээ бүхий биржийг техникийн дэвшилд тулгуурлан байгуулна. Хөдөөгийн иргэд мал, бусад бараа бүтээгдэхүүнээ байгаа, суугаа газар бүртээ зах зээлийн үнээр арилжиж мөн үнээр гол нэр төрлийн бараагаа худалдаж авах нөхцөлийг бүрэлдүүлнэ. | АН-н бүлэг                |
| 2.2.9.Цөмийн эрчим хүчийг ашиглах нарийвчилсан судалгаа хийж, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна. Цацрагийн хяналт, аюулгүй байдлыг сайжруулна.                                                                                                  | Эрчим хүчний шинэ, хямд эх үүсвэрүүдийг ашиглана. Цөмийн эрчим хүчийг ашиглах талаар нарийвчилсан судалгаа хийнэ                                                                                                                                                                                                        |                           |
| 2.2.18.Баруун чиглэлийн цахилгааны шугам сүлжээний алдагдлыг бууруулахын тулд Баянтээгийн нүүрсний уурхай дээр 20 мвт-ын станц байгуулна.                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                         | 3.Энхболд                 |
| 2.2.23.Эрчим хүчний салбарын эрх зүй, зах зээлийн загварыг боловсронгуй болгож, гэрээт зах зээлийн загварыг нэвтрүүлнэ.                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                                                                         | 3.Энхболд                 |
| 2.2.28.Экологийн цэвэр сүү, цагаан идээ, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                         | АН-н бүлэг                |
| 2.2.29.Үйлдвэржилт, жижиг, дунд үйлдвэрлэл болон ажил эрхлэлтийг дэмжихэд зориулж улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сан, гадаадын зээл тусламж, хувь хүний орлогын албан татварын орлого зэрэг эх үүсвэрүүдээс 150 тэрбумаас доошгүй төгрөгийг хуваарилна. | Ажил эрхлэлт, мэргэжлийн сургалт, үйлдвэржилтийг дэмжихэд зориулж 2009 оны улсын төсөв, хөгжлийн сангаас 150 тэрбум төгрөг зарцуулна. Жил бүр уг хөрөнгийн хэмжээг доод тал нь 2 дахин нэмэгдүүлж 2010 онд 300 тэрбум, 2011 онд 600 тэрбум төгрөг гаргана.                                                              | АН-н бүлэг                |
| 2.2.30.“Чацаргана” төслийг хэрэгжүүлэх, энэ төслийн хүрээнд улсын хэмжээнд эхний ээлжинд 20 мянган гектар талбайд чацаргана тариалж, түүнийг боловсруулах үйлдвэр байгуулна.                                                                                 | Сум бүрт 200 га-гаас багагүй ногоон байгууламж, чацарганы талбай нэмж байгуулна.                                                                                                                                                                                                                                        | АН-н бүлэг                |
| <b>2.3. Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын бодлого</b>                                                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                         |                           |

|                                                                                                                                                                                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                        |            |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|
| 2.3.1.Хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн мах, сүү, гурил, төмс, гол нэрийн хүнсний ногоогоор бүрэн хангах зохион байгуулалтын арга хэмжээ авна.                                                                                                                                                             | Хот, томоохон суурин газрын оршин суугчдыг хүнсээр хангах эрчимжсэн аж ахуй байгуулж мах, сүү, гурил, төмс хүнсний ногоог нөөцлөх агуулахын сүлжээг бий болгоно.                                                                                       |            |
| 2.3.12.Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг олон улсын жишгийн дагуу хийж, мал эмнэлгийн оношилгоо, шинжилгээний лабораторийн чадавхийг дээшлүүлэх, сумдын мал эмнэлэг, үржлийн нэгж болон Биокомбинатыг хөрөнгө оруулалтаар дэмжиж, дотоодын үйлдвэрийн малын эм, вакцины чанарыг сайжруулж, хангамжийг нэмэгдүүлнэ. | Малыг эрүүлжүүлэх, үүлдэр угсааг нь сайжруулахад зориулж жилд төсвөөс 30-аас доошгүй тэрбум төгрөг зарцуулна. Мал эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэхэд онцгой анхаарч, мэргэжилтэн тутамд ноогдох нормативыг ажлын ачааллыг нь харгалзан зохистой тогтооно. |            |
| 2.3.18.Хүлэмжийн ногоо болон жимс, жимсгэний аж ахуйг дэмжинэ.                                                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                        | Д.Одхүү    |
| 2.3.19.Малын угаалга, туулгалт, вакцинжуулалт зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг төрөөс хариуцан санхүүжүүлнэ.                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                        | АН-н бүлэг |
| <b>2.4. Дэд бүтэц, хот байгуулалтын бодлого</b>                                                                                                                                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                        |            |
| 2.4.5.Газар ашиглалтыг сайжруулж, газрын шинэтгэлийг эрчимжүүлэн Монгол Улсын иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.                                                                                                                                                                                           | Монгол улсын иргэнд газар өмчлөх эрхийг нь бодитой эдлүүлнэ. Хотын иргэд хөдөөд, хөдөөгийнх нь хотод газар, хөрөнгө өмчлөх эрхээ эдэлж, газар өмчлөлийг иргэд, өрх гэрийн амьдралд өгөөжтэй байхаар зохион байгуулна.                                  |            |
| 2.4.7.Нийслэл болон орон нутагт 100 мянган айлын орон сууц барих төсөл боловсруулж хэрэгжүүлнэ. Бага, дунд орлоготой иргэдийг орон сууцжуулах бодлогод ахиц дэвшил гаргана.                                                                                                                                                | Нийслэл болон төв суурин газрын ажилгүйдлийг арилгах, орлогыг нэмэгдүүлэх асуудлыг үйлдвэржилт, дэд бүтцийн хөгжил, орон сууцжуулах бодлоготой уялдуулан цогцоор нь шийдвэрлэнэ.                                                                       |            |
| 2.4.18. <b>Олон улсын авто замын сүлжээнд холбогдох Замын-Үүд-Улаанбаатар-Алтанбулаг</b> чиглэлийн хурдны зам болон Ярант-Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн хатуу хучилттай авто замыг барина.                                                                                                                             | Алтанбулаг-Улаанбаатар-Замын Үүдийн өндөр хурдны зам барина. Мөн чиглэлд төмөр замын хоёрдох шугамыг нээнэ.                                                                                                                                            |            |
| 2.4.21.Баянхонгор-Говь-Алтайн чиглэлийн хатуу хучилттай авто замыг барина.                                                                                                                                                                                                                                                 | Дорнод, Сүхбаатар, Өмнөговь, Дорноговь, Дундговь, Архангай, Хөвсгөл, Булган, Завхан, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Увс, Баян-Өлгий зэрэг аймгийн төвүүдийг засмал замаар холбоно.                                                                      |            |
| 2.4.30.Шуудангийн үндсэн сүлжээг өргөтгөн шинэчилж, мэдээллийн технологид суурилсан үйлчилгээг нэвтрүүлнэ.                                                                                                                                                                                                                 | Шуудан, харилцаа, холбооны бизнесийн эрчимтэй хөгжих орчин бүрдүүлнэ. Шуудангийн хаяг, кодын нэгдсэн систем нэвтрүүлнэ. Цахим худалдааг дэмжинэ.                                                                                                       |            |
| 2.4.32.Төмөр замын шинэ салаа зам байгуулах, хилийн гарцын тоог нэмэгдүүлэх, <b>хос шугам барьж, цахилгаанжуулах асуудлыг судалж, үе шаттайгаар шийдвэрлэнэ.</b>                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                        | АН-н бүлэг |
| 2.4.33.Орон сууц барих санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, орон сууцны урт хугацаатай зээлийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн тогтолцоог бий болгон орон сууцны урт хугацааны зээлийн жилийн хүүг бууруулж, эргэн төлөгдөх хугацааг 25 жил болгоно.                                                                     |                                                                                                                                                                                                                                                        | АН-н бүлэг |

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |            |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|
| 2.4.34.Газрын нэгдсэн төлөвлөгөөг Улсын Их Хурлаар батлуулж нийслэл, аймгийн төв болон төвлөрсөн суурингийн гэр хорооллыг барилгажуулахаас бусад газруудыг зөвхөн нээлттэй дуудлага худалдаагаар худалдах тогтолцоонд шилжинэ.                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | АН-н бүлэг |
| 2.4.35.Нийслэлийг шинэчлэн хөгжүүлэх “Шинэ Улаанбаатар-Ногоон нийслэл” хөтөлбөр гаргах, нийслэлд агаар болон хөрсний бохирдлыг бууруулах, дэд бүтцийн асуудлыг иж бүрэн шийдвэрлэх, хот байгуулалт, хот төлөвлөлтийн бодлогыг шинэчлэн баталж, хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэнг дүүрэг бүрт байгуулна. | Хот, суурин газар, аймаг, сумын төвд ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн байгуулан өргөжүүлэхийг дэмжинэ. Шинээр баригдах барилга байгууламжид орчны тохижилт, ногоон бүс хийх нэмэлт шаардлага тавина.                                                                                                                                                       |            |
| 2.4.36.Ховд, Чойбалсан, Дархан, Эрдэнэт, Замын-Үүд, Сүхбаатар хотуудыг улсын зэрэглэлтэй хотын статустай болгож, хотын хөгжлийн цогц арга хэмжээ авна.                                                                                                                                                                                             | Дархан, Эрдэнэт болон тодорхой шаардлага хангасан аймгийн төвүүд, зарим томоохон суурингуудыг хотын статустай болгож хөгжүүлэхийг мөн нийслэл, аймаг, хотын иргэд удирдлагаа-засаг даргаа шууд сонгодог тогтолцоонд шилжихийг зөв гэж үзнэ.                                                                                                                     |            |
| 2.4.37.Хөвсгөл нуурыг аялал жуулчлалын бүс болгон дэд бүтцийг нь тэргүүн ээлжинд хөгжүүлнэ.                                                                                                                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | Л.Гүндалай |
| <b>2.5. Орон нутгийн хөгжлийн бодлого</b>                                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |            |
| 2.5.7.Алслагдсан болон говийн бүсийн нэмэгдэл олгох оновчтой хэлбэрийг буй болгоно.                                                                                                                                                                                                                                                                | Алслагдсан болон говийн бүсийн аймаг, сумдын иргэдэд үзүүлэх зарим хөнгөлөлт үйлчилгээний оновчтой хэлбэрийг хэрэгжүүлнэ.                                                                                                                                                                                                                                       |            |
| 2.5.12.Улсын эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийх, тэргүүлэх ач холбогдол бүхий дэд бүтцийн бүтээн байгуулалтад гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор тус бүр нь 200.0 сая доллараас багагүй хөрөнгө шаардах 10 төслийг нэр заан 2009 онд багтаан нийтэд зарлана.                                                                     | Үйлдвэржилт, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын олон улсын стандартад нийцсэн 200 сая доллараас багагүй хөрөнгө шаардагдах эхний 10 төслийг 2009 онд багтаан нийтэд зарлана. Хөрөнгө оруулалтын төсөл, судалгаа гаргах үндэсний чадавхийг бий болгоно.                                                                                                               |            |
| <b>Гурав. Байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах зорилт:</b>                                                                                                                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |            |
| 3.2.Түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах, нүүрсийг боловсруулах, гэр хорооллыг орон сууцжуулахад зориулж инженерийн байгууламжийг өргөтгөх, ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх, нийтийн тээврийг шинэчилж хийн түлшинд шилжүүлэх замаар Улаанбаатар болон бусад хотуудын агаарын бохирдлыг бууруулна.                                        | - Улаанбаатарын агаарын бохирдол, утааны болон байгаль орчин, иргэдийн аюулгүй байдалд заналхийлж буй хорт бодис, хордлогын асуудлыг улс үндэстэнд тохиож байгаа нэн даруй шийдвэрлэх гамшиг гэж үзнэ. Үүнд олон улсын болон мэргэжлийн байгууллагууд, үндэсний чадавхийг бүрэн дайчилж, уг асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж цаг алдалгүй хэрэгжүүлнэ. | Д.Одхүү    |
| 3.3.Хот, суурин газрууд дахь агаар, ус, хөрсний бохирдлыг багасгаж, иргэдийн ажиллаж, амьдрах эрүүл орчныг бүрдүүлнэ.                                                                                                                                                                                                                              | - Нэн тэргүүнд утаатай байгууламжийг утаагүй, бохирдолгүй байгууламжаар солих санаачлагыг дэмжинэ. Гэр хороололд оршин суугчид шинээр орон сууцанд орвол ажил орлогоос нь хамааруулан орон сууцных нь зээлийн урьдчилгаа төлбөрийг төрөөс хариуцна.                                                                                                             |            |

|                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                       |              |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|
| 3.4.Хот, суурин газруудад хог хаягдлын шинэ менежментийг нэвтрүүлж, хог боловсруулах үйлдвэр байгуулна.                                                                                                                                                                                                                     | Улаанбаатар болон бусад төв сууринд хог хаягдлаас ангижрах, цэвэр усны хангамж, бохирын асуудлыг шийдвэрлэх орчин үеийн аргыг нэвтрүүлж, хог хаягдал боловсруулах үйлдвэр, цэвэрлэх байгууламж барих санал санаачлагыг дэмжинэ. Нийслэлийн хүн амын цэвэр усны нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлнэ. |              |
| 3.6.Говь, хээрийн болон цөлжилт ихээр явагдаж байгаа бүсүүдэд унаган ургамлыг тарималжуулах, хур тунадас нэмэгдүүлэх, ус хуримтлуулах, хиймэл нуур, цөөрөм байгуулах замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хангах арга хэмжээ авч, "Ус" хөтөлбөр хэрэгжүүлнэ.                                                                | Байгаль орчны эвдрэл сүйтгэл, цөлжилт хуурайшилт, ой ургамал, билчээрийн нөөц хомсдол талхлалттай тэмцэх үндсэн аргыг усжуулалтын бодлоготой нэн тэргүүнд уялдуулж "Ус" хөтөлбөр хэрэгжүүлнэ.                                                                                                                         |              |
| 3.7.Говь, хээрийн бүсийн бэлчээрийг усжуулах зориулалтаар баг бүрт нар, салхины эрчим хүчээр ажиллах тус бүр нэг худаг гаргана.                                                                                                                                                                                             | Говь хээр, цөлжилт ихээр явагдаж байгаа бүсүүдэд баян бүрд үүсгэх, худаг ус гаргах, усжуулах бүх л санал санаачлагыг дэмжинэ. Жил бүр хөдөө сумын баг бүрт усны нэг эх үүсвэр -худаг нэмж гаргана.                                                                                                                    | Я.Батсуурь   |
| 3.9.Хөрс хамгаалах эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, Хөрсний тухай хууль гаргаж хэрэгжүүлнэ.                                                                                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                                                                       | Г.Баярсайхан |
| 3.10.Алтны бага нөөцтэй шороон орд болон усны хагалбар, голын ай сав газар, ойн сан, говийн баян бүрд, байгалийн онцгой тогтоц бүхий газрууд, түүний хамгаалалтын бүсэд ашигт малтмал хайх, олборлохыг хориглох, байгаль орчин, хүний эрүүл мэндэд халтай арга технологиор уул уурхайн үйлдвэрлэл явуулахыг бүрэн зогсооно. | - Алтны 300 килограммаас ихгүй шороон болон үндсэн ордны ашиглалтыг зогсооно.<br>- Монгол улс, орон нутгийн стратегийн хөгжил, үйлдвэржилтийн бодлогод зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд ойн сав, усны хагалбар газарт ашигт малтмалын хайгуул, олборлолт явуулахыг хориглоно.                               |              |
| 3.11.Байгаль орчныг нөхөн сэргээх баталгаагүй бол эдийн засгийн ямар ч ашигтай хөтөлбөр төслөөс татгалзана.                                                                                                                                                                                                                 | Эхний зарчим нь байгаль орчин гэдэг бодлого баримталж, байгальд халтай, нөхөн сэргээх баталгаа байхгүй бол эдийн засгийн хувьд ямар ч ашигтай төсөл хөтөлбөрөөс татгалзана.                                                                                                                                           | Ц.Сэдваанчиг |
| <b>Дөрөв. Эрх зүйт төрийг төлөвшүүлж, засаглалын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох зорилт</b>                                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                       |              |
| <b>4.1. Эрх зүйн бодлого</b>                                                                                                                                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                       |              |
| 4.1.4.Шүүх эрх мэдлийн байгууллага хараат бус ажиллах эдийн засаг, зохион байгуулалтын орчныг бүрдүүлнэ.                                                                                                                                                                                                                    | Улс төрөөс хараат, иргэнээ алагчилдаг, хаалттай шүүхийг халж хараат бус, ил тод, иргэний эрх, эрх чөлөөт байдлыг хангахын төлөө ажилладаг шударга шүүхийн тогтолцоог бүрдүүлнэ. Шүүхийн хараат бус шударга ажиллах нөхцөлийг бүрэн бүрэлдүүлж, улсын төсөвт эзлэх шүүхийн төсвийн хувь хэмжээг хуульчилна.            | Э.Бат-Үүл    |
| <b>4.2. Гэмт хэрэгтэй тэмцэх бодлого</b>                                                                                                                                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                       |              |

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                         |            |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|
| 4.2.14. Авлигын гэмт хэрэг үйлдсэн албан тушаалтны улс, нийгэмд учруулсан мөнгөн хохирлыг тооцож нөхөн төлүүлдэг болох, авлигатай хийх тэмцлийг эрчимжүүлж, ялын бодлогыг чангатгана.                                                                                                                                                                                     | - Авлигын гэмт хэрэг үйлдсэн албан тушаалтны улс нийгэмд учруулсан мөнгөн хохиролыг нэмэгдэл ялд тооцож нөхөн төлүүлдэг болно. Авсан авлигын нэг сая төгрөг тутамд нэг жилийн нэмэгдэл ял ноогдуулахаар хуульчилна.                     | АН-н бүлэг |
| <b>4.4. Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгож бэхжүүлэх</b>                                                                                                                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                         |            |
| 4.4.1. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллага сонгуулийн насны хүн амын бүртгэлийг тусад нь хөтлөх журамд шилжиж, Сонгуулийн Ерөнхий Хорооны чиг үүрэгт сонгогчдын бүртгэлд хяналт тавих асуудлыг хуульчилна.                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                         | АН-н бүлэг |
| <b>4.5. Иргэний нийгэм, төрийн удирдлагын бодлого</b>                                                                                                                                                                                                                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                         |            |
| 4.5.3. Бүх шатны сонгуулийн хууль тогтоомжийг иргэдийн төрийг удирдах хэрэгт оролцох, сонгох, сонгогдох эрхийг хангах, чөлөөт, бүх нийтийн, тэгш, шууд сонгуулийг бэхжүүлэх агуулгаар шинэчилнэ.                                                                                                                                                                          | Сонгуулийн болон сонгуулийн санхүүжилтийн хуулийг ардчилсан, иргэнлэг, шударга байх жишигт нийцүүлэн өөрчилнэ.                                                                                                                          |            |
| 4.5.4. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны уялдааг хангасан, иргэнд үйлчлэх үндсэн чиг үүрэг бүхий, авлига, хүнд суртлаас ангид, чадварлаг, хариуцлагатай төрийн албыг хөгжүүлэх чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүнд сурталгүй болгож хариуцлагыг дээшлүүлнэ. | Төрийн албаны хуулийг өөрчилж төрийн албыг иргэдэд, олон нийтэд үйлчилдэг үйлчилгээ болгон хэвшүүлнэ. Төрийн албан хаагчид зээлийн тогтолцоонд хамрагдахыг урамшуулж, хуулийн хүрээнд шударгаар ажиллаж амьдрахад нь тусална.           |            |
| <b>Тав. Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын зорилт:</b>                                                                                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                         |            |
| <b>5.1. Гадаад бодлого</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                                                         |            |
| 5.1.1. Нээлттэй олон тулгуурт улс төр, эдийн засгийн дипломат гадаад бодлогын хүрээнд ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн түншлэлийн, АНУ, Япон, Европын холбоотой иж бүрэн түншлэлийн харилцааг, бусад улс орнуудтай тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлнэ.                                                                                     | Сайн хөршийн найрсаг харилцаагаа улам бэхжүүлж, Ази, бүс нутгийн эдийн засаг, нийгмийн интеграцчилалд идэвхтэй оролцож, гадаад харилцааны уламжлалт чанарыг хадгална.                                                                   |            |
| 5.1.3. Бүс нутгийн улс төр, эдийн засгийн харилцаанд оновчтой оролцох, Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага /АПЕК/-д элсэх чиглэлээр ажиллана.                                                                                                                                                                                                 | Сайн хөршийн найрсаг харилцаагаа улам бэхжүүлж, Ази, бүс нутгийн эдийн засаг, нийгмийн интеграцчилалд идэвхтэй оролцож, гадаад харилцааны уламжлалт чанарыг хадгална.                                                                   |            |
| <b>5.3. Гамшгаас сэргийлэх, хор нөлөөг арилгах үндэсний чадавхи бэхжүүлэх бодлого</b>                                                                                                                                                                                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                         |            |
| 5.3.2. Гамшгаас сэргийлэх, аврах, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг бууруулах, түүний хор уршгийг арилгах үндэсний чадавхийг нэмэгдүүлж, шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.                                                                              | Иргэдийн аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангах болон онцгой нөхцөл, хямрал, гамшгийн үед ажиллах үндэсний болон аймаг нийслэлийн байгууллагын чадавхийг нэмэгдүүлж, мэргэжлийн болон техникийн хангалтын түвшинг дээшлүүлнэ. |            |

## МОНГОЛ УЛСЫН 2009 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Монгол Улсын 2009 онд баримталсан төсвийн бодлого нь төсвийн тэнцлийг макро эдийн засгийн бодлогын зорилтууд, мөнгөний бодлоготой уялдуулан оновчтой тогтоож, төрийн албаны орон тоо болон цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй байж, амин чухал биш хөрөнгө оруулалт, тэвчиж болох урсгал зардлыг багасгах замаар эх үүсвэрийг чөлөөлж, тогтмол зардлын үнийн өсөлтийг санхүүжүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээг гагцхүү хэрэгцээтэй нийгмийн бүлгүүдэд зориулахад чиглэгдсэн, төсвийн хумих бодлогыг баримтлан төсвийг боловсруулжээ.

Монгол Улсын 2009 оны төсвийн төслийг боловсруулахдаа дараах зарчмуудыг баримталсан. Үүнд:

- Засгийн газрын зарлагыг хязгаарлах, цалин, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамжийн зарлагыг нэмэгдүүлэхгүй байх;
- Төрийн албаны орон тоо, зардлыг нэмэгдүүлэхгүй байх, амин чухал бус хөрөнгө оруулалт, тэвчиж болох урсгал зардлыг багасгах;
- Засгийн газрын үйл ажиллагааны бодлого, хөтөлбөр, авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээнээс ач холбогдол, эрэмбэ дарааллыг харгалзан төсөвт тусгах;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын явц, гүйцэтгэлтэй уялдуулан авч үзэх, 2009 онд ашиглалтанд орох боломжтой барилгад хүч хөрөнгийг төвлөрүүлэх;
- Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, салбаруудын тогтвортой хөгжлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлийг баримтлах;
- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулан хөрөнгийн дотоод эх үүсвэрийг шийдвэрлэх, салбарын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан зохицуулах;
- Хууль, эрх зүйн орчны өөрчлөлт болон Засгийн газрын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийг шавхан дайчлах;
- Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг тооцох;
- Төсвийн хүрээний мэдэгдлээр батлагдсан үзүүлэлтүүдийг хангах;
- Төсвийн тэнцвэрт харьцааг хадгалах хэмжээнд орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчлах;
- төсвийн орлогын тогтвортой бааз суурийг өргөжүүлэх, татвар хураалтыг эрчимжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх;
- Дэлхийн зах зээл дахь зэс, алтны үнийн нөлөөллийг тооцох;
- Хөтөлбөрт суурилсан дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг хөтөлбөрөөр төлөвлөх;
- Төсөвт учирч болох эрсдлийг бүрэн тооцох;

Улсын Их Хурлаас 2009 оны төсвийг дөрвөн үе шаттай хэлэлцсэн бөгөөд тухай бүр холбогдох өөрчлөлт, тайлбар, танилцуулгыг бэлтгэн ажиллаж Улсын Их хурлын нэгдсэн чуулганы 2008 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2009 оны төсвийн тухай, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуулиудыг батлуулсан болно.

Батлагдсан төсвөөр Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2.2 их наяд буюу ДНБ-ний 34.3 хувь, зарлага 2.6 их наяд буюу ДНБ-ний 40.4 хувь, нэгдсэн төсвийн нийт алдагдал 395.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 6.1 хувь болохоор байна.

**Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс татан төвлөрүүлэх орлого**

Монгол Улсын төсвөөс 2009 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг

| Д/д | Аймаг       | Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/ |
|-----|-------------|----------------------------------------------------|
| 1   | Архангай    | 1,983.1                                            |
| 2   | Баян-Өлгий  | 2,136.9                                            |
| 3   | Баянхонгор  | 2,393.7                                            |
| 4   | Булган      | 59.4                                               |
| 5   | Говь-Алтай  | 2,042.4                                            |
| 6   | Дундговь    | 1,978.8                                            |
| 7   | Завхан      | 2,595.4                                            |
| 8   | Өвөрхангай  | 2,639.9                                            |
| 9   | Увс         | 3,011.9                                            |
| 10  | Ховд        | 2,229.2                                            |
| 11  | Хөвсгөл     | 2,979.0                                            |
| 12  | Говь-Сүмбэр | 1,179.1                                            |
|     | Нийт дүн    | 25,228.8                                           |

Орон нутгийн төсвөөс улсын төсөвт татан төвлөрүүлэх орлогын хэмжээг

| Д/д | Аймаг     | Татан төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/ |
|-----|-----------|--------------------------------------------------|
| 1   | Дорноговь | 3,286.4                                          |
| 2   | Дорнод    | 354.5                                            |
| 3   | Өмнөговь  | 10,093.4                                         |
| 4   | Сүхбаатар | 528.1                                            |
| 5   | Сэлэнгэ   | 5,233.3                                          |

тус тус төсөв тэнцлийн хувьд сайжирч батлагдсан юм.

**Орон нутгийн төсвийн зарлагад 2008 оноос 2009 онд гарсан өөрчлөлт**

2008 онд орон нутгийн хөрөнгө оруулалтад зориулж нийт 20 тэрбум төгрөгийг аймгуудын орон нутгийн төсвийн зарлага талд суулгаж батлуулсан бол 2009 онд аймгуудын хөрөнгө оруулалтад зориулж 14.4 тэрбум төгрөгийг Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталж өгсөн.

2008 онд 4.3 тэрбум төгрөгийг орон гэргүй хүмүүст гэр олгоход зориулан аймгуудын төсөвт тусган батлуулсан бол 2009 онд энэхүү хөрөнгийн дахин тусгаагүй.

Жижиг дунд үйлдвэрийг нэмэгдүүлэх зорилгоор аймаг, дүүрэг бүрт 1 тэрбум төгрөг нийтдээ 30 тэрбум төгрөгийг орон нутгийг төсөвт тусган батлуулсан.

Орон нутгийн төсвийн орлого 2008 онд 165.9 тэрбум төгрөг байсан бол 2009 онд 236.8 тэрбум төгрөг болж 70.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

### ***Орон нутгийн төсвийн орлогод 2008 оноос 2009 онд гарсан өөрчлөлт***

2009 оноос эхлэн хувь хүний орлогын албан татвар болох 100.6 тэрбум төгрөгийг орон нутгийн орлогод шилжүүлсэн.

2008 онд орон нутагт Улсын төсвөөс 29.7 тэрбум төгрөгийн НӨАТ-ын шилжүүлэг олгож байсан бол 2009 онд НӨАТ-ын орлогыг 100 хувь улсын төсөвт төвлөрүүлэх болсон.

### ***Орон нутгийн 2009 оны төсвийг хэрэгжүүлэхдээ анхаарах асуудлууд***

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын хуваарийг олгогдсон хугацаатай нь уялдуулан боловсруулж, нийт дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар үндэслэлгүй нэмэгдүүлж, хасагдуулахгүй байх;

Орон нутгийн эрчим хүчний зөвлөлөөс төсөв батлагдсаны дараа тогтмол зардлын үнэ, тарифыг өөрчлөхгүй байх, төсвийн төлөвлөгөөнд тусгасан үнэ, тарифыг мөрдөж ажиллах;

Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, ажлын явц, үр өгөөжийг нэмэгдүүлж ажиллах;

Төсвийн орлого бүрдэлттэй уялдуулан төсвийн зарлага, санхүүжилтийг хийх;

## **ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2009 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ УИХ-ЫН ТОГТООЛ**

Энэхүү хуулийн төслийг судлахад УИХ дахь Ардчилсан намын бүлгээс УИХ-ын гишүүн Н.Батбаяр, Д.Ганхуяг, Д.Зоригт, З.Энхболд нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Энэ ажлын хэсэг УИХ дахь МАХН-ын бүлгийн ажлын хэсэгтэй зөвшилцөн төслийг дэмжсэн бөгөөд 2008 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр УИХ-ын ээлжит чуулганаар баталсан билээ.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэлийн гол зорилт нь хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийг 2009 оны эцэст 12.0 хувь, 2010 оны эцэст 10.0 хувь, 2011 онд 6.5 хувь байхаар тооцсон. Төсвийн тэлэх бодлого 2008 онд үргэлжилж төрийн албан хаагчдын цалингийн өсөлт 2008 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн 90 гаруй хувиар өссөний зэрэгцээ нийгмийн халамжийн зардлууд, төсвийн хөрөнгө оруулалт ч нэмэгдсэн.

Манай орны гол экспортыг бүрдүүлдэг уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үнэ өссөний үр дүнд улсын төсвийн орлого нэмэгдсэн. Орлого өсөхийн хэрээр зарлага нэмэгдэж байгаа ч зарлагын өсөлтийн хурд нь орлогынхоосоо илт давах болсон. Төсвийн зарлага ийнхүү хурдтай нэмэгдсэн нь мөнгөний нийлүүлэлтийг өсгөсөн. Ингэж өссөн мөнгөний нийлүүлэлтийг бууруулах мөнгөний бодлогын арга хэмжээ нь эцэсдээ нийт эдийн засгийн хэмжээнд хүүгийн түвшинг нэмэгдүүлэх үр дагавартай байх тул хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бууруулдаг сул талтай.

Эдийн засагчид төрийн сангийн энэхүү бодлогыг “хувийн хөрөнгө оруулалтыг шахан гаргах” сөрөг үр дагавар хэмээн нэрлэж, үүнээс макро эдийн засгийн бодлого тодорхойлогчид зайлсхийхийг эрмэлздэг билээ. Төсвийн зарлага хүчтэй нэмэгдсэнээр инфляцийг улам өсгөх болсон энэ үед төсвийн зарцуулалтыг ажил, үйлчилгээний гүйцэтгэлтэй айтар уялдуулах замаар үр ашгийг нь нэмэгдүүлэх, үр өгөөж муутай нийгмийн халамж, хөрөнгө оруулалтын арга хэмжээнээс татгалзах зайлшгүй шаардлагатай болсон.

## **БАНКИН ДАХЬ МӨНГӨН ХАДГАЛАМЖИД БАТАЛГАА ГАРГАХ ТУХАЙ ХУУЛЬ**

Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж Улсын Их Хуралд 2008 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийг Улсын Их Хурал 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталлаа.

Энэ хууль нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор арилжааны банкин дахь мөнгөн хадгаламжид төрөөс баталгаа гаргахтай холбогдсон харилцааг зохицуулах юм.

Олон улсын санхүүгийн зах зээлийн хямрал гүнзгийрч байгаа нь манай улсын банкны салбарт шууд нөлөөлөхгүй ч уг хямралын нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор арилжааны банкин дахь мөнгөн хадгаламжийн баталгааг төрөөс гаргах нь зүйтэй гэж үзэж уг хуулийг баталлаа.

Энэхүү баталгаа нь мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий, Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкинд хамаарна. Баталгааны хүчинтэй байх хугацаа нь хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 4 жил байна. Уг хугацаанд арилжааны банкин дахь мөнгөн хадгаламжид хохирол учирсан тохиолдолд төр хохирлыг бүрэн хариуцах юм.

Энэ хууль батлагдсанаар банкны болон санхүүгийн салбарын тогтвортой байдал хадгалагдаж, олон улсын санхүүгийн хямралын нөлөөллөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэх, иргэдийн банкинд итгэх итгэл нь бэхжих ач холбогдолтой юм.

## **МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

Сүүлийн жилүүдэд мал хулгайлах гэмт хэрэг өсч байгаа нь малчид, мал бүхий иргэдийн амьдралд хүндээр тусч тэдний сэтгэлийг зовоосон асуудал болоод байгаа төдийгүй төр, засгаас ч анхаарч тодорхой арга хэмжээ авах шаардлагатай болсон юм.

Иймээс мал хулгайлах, мал, мах бэлтгэх зориулалтаар гарал үүслийн гэрчилгээгүй мал тууварлах, хууль бусаар мал, мах бэлтгэх, тээвэрлэх явдлыг таслан зогсоох зорилгоор Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс санаачлан боловсруулж өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал хэлэлцэж, 2008 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа батлан гаргалаа.

Хуулийн 1 дүгээр зүйлээр Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмэв.

1/ 4 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг:

“4.3.Иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгаар мал сүргийг хамгаалах зорилготой малчид, мал бүхий иргэдийн бүлгийг баг, хороонд ажиллуулж болох бөгөөд бүлгийн үлгэрчилсэн дүрмийг хүнс, хөдөө аж ахуйн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.4.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй ажиллаж байгаа малчид, мал бүхий иргэдийн бүлгийг холбооны болон бусад техник хэрэгслээр хангахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.”

2/ 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“8.2.Тээврийн хэрэгслийн жолооч нь мах бэлтгэлийн зориулалттай мал, махыг тээвэрлэхдээ гарал үүслийн гэрчилгээтэй эсэхийг нь шалгасны үндсэн дээр тээвэрлэнэ.”

3/ 11 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг:

“11.4.Алдуул болон хулгайлагдсан малыг бүртгэх, мэдээлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.5.Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх зорилгоор нийт малыг бүртгэх, бүртгэлийг тухай бүр шинэчлэх ажлыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хариуцаж, холбогдох бүртгэлийн журмыг батална.”

4/16 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4 дэх заалт:

“16.5.4.харъяа нутаг дэвсгэртээ байгаа малыг индексжүүлсэн тамгын сүлжээнд бүрэн хамруулж холбогдох бүртгэл, хөдөлгөөнийг байнга хийж байгаа болон мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээг тогтмол хэрэглэж хэвшүүлэх ажлыг зохион байгуулж байгаа албан тушаалтныг шагнаж урамшуулах.”

Хуулийн 2 дугаар зүйлээр Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “энэ хуулийн” гэсний дараа “7.1.1-д заасныг биелүүлээгүй,” гэж нэмэв.

4/ Хуулийн 3 дугаар зүйлээр Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулав.

“17.1.1.мал, мах бэлтгэлийн зориулалтаар гарал үүслийн гэрчилгээгүй мал тууварласан, мал, мах тээвэрлэсэн, тусгайлан бэлтгэсэн төвлөрсөн цэгээс өөр газарт мал, мах бэлтгэсэн бол хууль бусаар тууварласан, тээвэрлэсэн, бэлтгэсэн мал, махыг болон зөрчил гаргахад ашигласан уналга, тээврийн хэрэгслийг хураан зөрчлийг илрүүлсэн орон нутгийн төсвийн орлого болгож, зөрчил гаргасан иргэнийг 50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 250000 төгрөгөөр торгох;”

5/ Хуулийн 4 дүгээр зүйлээр Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “олон тооны” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.3 дахь заалтын “хүртэл” гэснийг тус тус хасав.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль нь мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг бууруулахад чиглэгдсэн эрх зүйн чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

## **МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАХ ТУХАЙ**

Улсын Их Хурал 2008 оны 10 дугаар сарын 9-ны өдөр “Монгол Улсыг хөгжүүлэх сангаас хөрөнгө зарцуулах тухай” хуулийг баталсан.

Уг хууль батлагдсанаар 2007 оны жилийн эцсийн мал тоологын дүнг үндэслэн ямааны тоогоор тооцож нэг килограмм ноолуур тутамд 5000 төгрөгийг малчид болон мал бүхий иргэнд олгохоор болсон.

Энэхүү нэг удаагын арга хэмжээний хүрээнд хэмжээнд шаардагдах 30.5 тэрбум /гучин тэрбум таван зуун сая/ төгрөгийг Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхээр хуульчлан тогтоож өгсөн.

Зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдөж малчдын бодит орлогын эх үүсвэр болох ноолуур болон малын гаралтай түүхий эдийн үнэ ханш уналтад орж малчдын гар дээрх бэлэн мөнгөний эргэлт хомсдсонтой уялдуулан энэхүү хуулиар доорх зорилгыг хэрэгжүүлэх чиглэл тусгагдсан юм. Үүнд:

- Өргөн хэрэглээний бараа бүтээгдхүүний үнэ эрс өсч, ноолуурын үнэ ханш огцом унаж байгаа энэ үед малчдын амьжиргааг зах зээлийн эрсдэлээс хамгаалах
- Малчдын бодит орлогыг нэмэгдүүлэх
- Ноолуурын үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зэрэг асуудлууд болно.

## **“ХҮНСНИЙ НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ” ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

Улсын Их Хурал 2008 оны 12 дугаар сарын 11-ний өдөр “Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарим хэсгийг буудайн нөөц хэлбэрээр байршуулах тухай” тогтоолын төслийг баталсан.

Уг тогтоолын төслөөр Монгол Улсыг хөгжүүлэх санд хүнсний буудайн нөөц хэлбэрээр байршуулах 100 сянган тонн буудайг худалдан авах, тээвэрлэх, хадгалах, зардалд шаардагдах 40 тэрбум төгрөгийг Монгол Улсыг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэхээр болсон.

Манай улс нь сүүлийн жилүүдэд дотоодын хэрэгцээт гурилынхаа 30 орчим хувийг дотоодын улаанбуудайгаар, 10 гаруй хувийг тусламжийн буудайгаар хангаж, 60 орчим хувийг нь гурил, буудай байдлаар импортолж байсан юм.

2008 оны хувьд Монгол Улсын Засгийн газраас батлан хэрэгжүүлж байгаа “Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийн үр дүн, газар тариалангийн салбарт нэвтрүүлсэн техник, технологийн шинэчлэл нь өснөх жилүүдтэй харьцуулахад буудайн ургац их хэмжээгээр хураан авах үндсэн нөхцөл болсон байна.

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 6.5-д заасны дагуу хүнсний буудайн нөөц хэлбэрээр дотоодын үйлдвэрлэлийг дэмжсэн бодлогын нэг илрэл байлаа.

Гурил, гурилан бүтээгдхүүн нь хэрэглээний үнийн индексээр тодорхойлогдох өргөн хэрэглээний бараа үйлчилгээ, хүн амын үндсэн хэрэглээний нэг бөгөөд хэрэглээний

сагсанд чухал байр эзэлдэг тул улирлын нийлүүлэлтээс шалтгаалан инфляцид ихээр нөлөөлж байдаг.

Иймд “Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарим хэсгийг буудайн нөөц хэлбэрээр байршуулах тухай” тогтоол нь дараах зорилгыг хангахад чиглэгдсэн байна. Үүнд:

- Хүн амыг гурил, гурилан бүтээгдхүүнээр хангах
- Өргөн хэрэглээний бараа үнийн өсөлтөөс сэргийлэх
- Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зэрэг болно.

## **“ГАДААДЫН АЛБАН ЁСНЫ БИЧИГ БАРИМТЫГ БАТАЛГААЖУУЛАХ ШААРДЛАГЫГ ХАЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

Энэхүү хуулийн төслийг УИХ дахь Ардчилсан намын бүлэг дэмжсэн бөгөөд 2008 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан билээ.

Нэг улсын нутаг дэвсгэр дээр үйлдсэн бичиг баримтыг нөгөө улсын нутаг дэвсгэр дээр хэрэглэх тохиолдолд тухайн бичиг баримт нь жинхэнэ эсэх, хууль зүйн хувьд хүчинтэй эсэх талаар практикийн болон хууль зүйн эргэлзээ үүсдэг. Энэ эргэлзээг бичиг баримтыг баталгаажуулах замаар арилгадаг.

Олон улсын хэмжээнд өөр улсад хэрэглэх бичиг баримтыг олон улсын зан заншлын хэм хэмжээ болон 1961 онд баталсан “Гадаадын албан ёсны бичиг баримтыг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенц” буюу олон улсад “Apostille” конвенц хэмээн нэрлэгддэг конвенцийн дагуу баталгаажуулж байна.

Олон улсын заншлын хэм хэмжээний дагуу гадаад улсад үйлдсэн бичиг баримтад тухайн бичиг баримт хэрэглэгдэх орны дипломат төлөөлөгчийн болон консулын газар консулын баталгаа хийх замаар баталгаажуулт хийдэг. Ийм консулын баталгаа хийхийн тулд тухайн бичиг баримтыг үйлдсэн улсын төрийн захиргааны зохих байгууллага буюу практикт голчлон Гадаад хэргийн яамаар урьдчилан баталгаажуулахыг шаарддаг. Бичиг баримт баталгаажуулах энэ уламжлалт арга нь баталгаажуулалтын гинжин хэлхээг үүсгэж, хоёр талдаа цаг, зардал ихээхэн шаардсан хүнд сурталтай процессыг бий болгодог сул талтай.

Бичиг баримт баталгаажуулалтын энэ гинжин хэлхээг хялбаршуулах, аль улсад үйлдсэнээс нь үл харгалзан олон улсад хүлээн зөвшөөрөх нөхцлийг хөнгөвчлөх, хэрэглээний эргэлтийг нь сайжруулах, улмаар олон улсын харилцааг идэвхжүүлэх зорилгоор Олон улсын хувийн эрх зүйн Гаагийн есдүгээр бага хурлаас 1961 оны 10 дугаар сарын 5-ны өдөр “Гадаадын албан ёсны бичиг баримтыг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенц”-ийг баталсан.

Энэхүү конвенцоор дипломат төлөөлөгчийн болон консулын газар бичиг баримт баталгаажуулдаг практикыг халж баталгаажуулалтын хялбаршуулсан хэм хэмжээг тогтоосон. Конвенцийн дагуу гадаад улсад хэрэглэгдэх бичиг баримтыг тухайн бичиг баримт үйлдэгдсэн улсын төрийн захиргааны зохих байгууллага баталгаажуулж “Apostille” гэрчилгээ олгосноор тухайн бичиг баримт нь баталгаажсанд тооцогдон Конвенцийн гишүүн улсуудад шууд хүлээн зөвшөөрөгдөн хэрэглэгддэг. “Apostille” гэрчилгээгээр баталгаажуулсан бичиг баримтыг Конвенцийн гишүүн улсуудад хэрэглэх тохиолдолд тухайн бичиг баримтыг дахин баталгаажуулахыг шаарддаггүй.

Манай улс “Apostille” конвенцид нэгдэн орохыг соёрхон батлах хууль зүйн болон практик дараахь шаардлага байсан.

Одоогийн байдлаар олон улсын зан заншлын хэм хэмжээний дагуу хилийн чанадад хэрэглэх дотоодын албан ёсны бичиг баримтыг нотариатаар гэрчилсний дараа Гадаад хэргийн яамнаас консулын баталгаа хийж байна. Гадаад хэргийн яам гэрчилж баталгаажуулсан бичиг баримтыг хүлээн зөвшөөрөх, дахин баталгаажуулах эсэх нь тухайн бичиг баримт хэрэглэгдэх улсаас хамаарч байна. Тухайлбал, ХБНГУ-ын ЭСЯ 2003 оноос өмнөх манай консулын баталгааг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ мэдэгдсэн, мөн Европын олон оронд Монголын нотариатын гэрчилгээ, консулын баталгааг хүлээн зөвшөөрөхгүй иргэдийг чирэгдүүлэх явдал гарсаар байна.

Гадаад улсад үйлдсэн бичиг баримтыг хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн болон консулын газар консулын баталгаа гаргахаар Монгол Улсын Консулын дүрмийн 13.3-т заасан бөгөөд уг баталгаа гаргах журмыг Гадаад хэргийн яам тогтоохоор заасан боловч ийм журам гараагүй байна. Үүнээс гадна энэ харилцааг бусад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээгээр зохицуулж байгаа боловч ийм төрлийн хэлэлцээр харьцангуй цөөн байгуулагдсан, хэлэлцээрийн хамрах бичиг баримт нь зөвхөн хууль, шүүхийн байгууллагын бичиг баримтаар хязгаарлагдаж байгаа юм. Дүгнэн хэлэхэд гадаад улсад хэрэглэгдэх дотоодын, манай улсад хэрэглэгдэх гадаадын бичиг баримтыг баталгаажуулах харилцааг зохицуулсан олон улсын болон үндэсний эрх зүйн хэм хэмжээ манай улсад байхгүй байна.

“Apostille” конвенцид нэгдэн орохыг соёрхон баталснаар түүний гишүүн 93 улстай бичиг баримтыг хэрхэн баталгаажуулж, харилцан хүлээн зөвшөөрөх талаар эрх зүйн зохицуулалттай болох юм.

“Apostille” конвенцид бичиг баримт баталгаажуулах гэж бичиг баримтан дээрх гарын үсэг нь жинхэнэ эсэх, гарын үсэг зурсан этгээд нь тийм эрхтэй эсэх болон дарагдсан тамга, тэмдгийн эх сурвалжийг гэрчлэх үйлдэл хэмээн тодорхойлсон. Монгол Улсын Нотариатын тухай хуулиар бичиг баримт гэрчлэх, баталгаажуулах эрх зөвхөн нотариатч, нотариатын үүрэг гүйцэтгэгч нарт байдаг. Олон улсын практикыг харгалзан бичиг баримт баталгаажуулж, “Apostille” гэрчилгээ олгох эрхийг гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад олгох нь оновчтой байгаа юм. Ингэсэн тохиолдолд Гадаад хэргийн яам бичиг баримт баталгаажуулах, нотариатын үйлдлийг дахин баталгаажуулах эрхтэй болох тул Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 10.2-т заасныг удирдлага болгон энэ конвенцид нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөл, түүний үзэл баримтлалыг боловсруулсан болно.

Хилийн чанадад монгол иргэдийн шилжилт хөдөлгөөн, оршин суух, суралцах явдал нэмэгдэхийн хэрээр иргэний бүртгэл хөтлөх, боловсрол эзэмших, эд хөрөнгө эзэмших болон захиран зарцуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх гэхчилэн тэдэнтэй холбоотой асуудлаар Монгол Улсын албан ёсны баталгаажсан бичиг баримт олгох, эсхүл гадаадад үйлдсэн ийм төрлийн бичиг баримтыг дотоодод хэрэглэх шаардлага нэмэгдэж, энэ нь иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудлын чухал хэсэг болон тавигдаж байна. Гадаад хэргийн яам долоо хоногт энгийн үед 500-700, ачаалал ихтэй үед 2500-3000 хуудас материалд нэг хуудсыг 400 төгрөгийн хураамжтайгаар консулын баталгаа хийдэг.

Конвенцид нэгдэн орохыг соёрхон баталснаар төрийн захиргааны болон орон нутгийн захиргааны байгууллага, шүүх, хууль хяналтын байгууллагын бичиг баримт, иргэний үнэмлэх, төрсний болон гэрлэлтийн гэрчилгээ зэрэг иргэний болон гэр бүлийн байдлын бүртгэлийн бичиг баримт, боловсролын гэрчилгээ, диплом, хуулийн этгээдийн

бүртгэлийн гэрчилгээ, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ, патент зэрэг иргэд, хуулийн этгээдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхтэй холбоотой бичиг баримт, нотариатч гэрчлэн баталгаажуулсан бичиг баримт зэрэг маш олон төрлийн бичиг баримтыг Гадаад хэргийн яам баталгаажуулж, “Apostille” гэрчилгээ олгосноор конвенцийн гишүүн улсуудад дахин аливаа төрлийн баталгаажуулалт хийлгэхгүйгээр шууд хэрэглэх болно. Ингэснээр энэ асуудлыг олон улсын эрх зүйн хүрээнд шийдвэрлэх боломж бүрдэх юм.

“Гадаадын албан ёсны бичиг баримтыг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенц” нь 15 зүйл, нэг Хавсралттай бөгөөд 1964 оны 1 дүгээр сарын 24-нд хүчин төгөлдөр болсон. Одоогийн байдлаар энэхүү конвенцид Австрали, Австри, АНУ, Англи, Беларусь, Бельги, Герман, Грек, Израйль, Ирланд, Испани, Итали, Лихтенштейн, Люксембург, Нидерланд, Норвег, ОХУ, Португаль, Турк, Унгар, Финланд, Франц, Чех, Швед, Швейцарь, Япон, БНСУ зэрэг 93 улс нэгдэн ороод байна.

Конвенцид нэгдэн орсныг соёрхон батлах тухай хууль нь 3 зүйлтэй. Хуулийн 1 дүгээр зүйлд конвенцид нэгдэн орсныг соёрхон батлахаар, 2 дугаар зүйлд бичиг баримт баталгаажуулж, “Apostille” гэрчилгээ олгох эрхийг конвенцийг хэрэгжүүлж буй олон улсын практикт үндэслэн Гадаад хэргийн яаманд олгохоор, 3 дугаар зүйлд конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах журмыг батлах эрхийг гадаад хэргийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнд олгохоор тус тус баталсан.

Конвенцийн гишүүн болсноор манай улсын хувьд санхүүгийн ямар нэгэн хүндрэл үүсэхгүй бөгөөд гарах бодит зардал нь бичиг баримтыг баталгаажуулж, “Apostille” гэрчилгээ олгох үйл ажиллагааны зардал байх боловч уг зардлыг бичиг баримт баталгаажуулж, “Apostille” гэрчилгээ олгосон үйлчилгээнээс авах хураамжийн хэлбэрээр улсын төсөвт буцаан оруулах юм.

## **“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ”, “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИЙН НЭМЭЛТ ПРОТОКОЛ”-ЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

Энэхүү хуулийн төслийг УИХ дахь Ардчилсан намын бүлэг дэмжсэн бөгөөд 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр баталсан билээ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 61/106 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протоколыг баталсан.

Уг конвенцид дэлхийн 125 орон нэгдэн ороод байгаа бөгөөд үүнээс 16 орон соёрхон баталсан байна. Нэмэлт протоколд 71 орон нэгдэн орсноос 10 орон соёрхон баталсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн эрх, эрх чөлөөгөө эдлэх тэгш боломжийг бий болгохын тулд тэдний тусгай хэрэгцээнд нийцсэн эрх зүй, нийгэм, улс төр, эдийн засгийн болон дэд бүтэц, сэтгэл зүйн орчинг бүрдүүлэх зайлшгүй шаардлага байсан.

Манай улсад 115.0 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг. Улсын хэмжээнд хөдөлмөр эрхэлж байгаа нийт иргэдийн 1.9 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Үндэсний Статистикийн газрын судалгаагаар хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 56.9 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж, 12.8 хувь нь гэрээгээр ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь харилцан адилгүй хөдөлмөрийн чадвартай байдаг төдийгүй ажлын тусгай орчин, нөхцлийг шаарддаг тул ажил олгогчид хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийг ажил авах сонирхолгүй байдаг. Иймээс аж ахуйн нэгж, байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллах боломж тэр бүр олддоггүй байна.

Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих квотын систем боловсронгуй бус, аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн чадавхи сул зэргээс хамааран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар авч хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодлого төдийлөн үр дүнд хүрэхгүй байгаа юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн эрх, эрх чөлөөгөө бүрэн эдлэх дэд бүтэц, орчинг бүрдүүлж чадаагүй, тэдэнд чиглэсэн эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус байгаагаас тэдгээр иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдсөөр байна.

Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протоколыг соёрхон батласан билээ.

Энэхүү хууль батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна.

1/Конвенц, түүний нэмэлт протоколыг соёрхон баталснаар төрийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, нийгмийн баталгааг сайжруулахад чухал алхам болно.

2/Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагчид нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, баялаг бүтээх үйл явцад хувь нэмрээ оруулах боломж нөхцөл бүрдэнэ. Ингэснээр тэдний амьжиргааны түвшин дээшилнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангахад төрөөс тодорхой хэмжээний төсөв, хөрөнгө шаардлагатай боловч конвенцийн 4.2-д заасны дагуу энэ үүргээ аажмаар ахиц гаргах замаар хэрэгжүүлж болох юм. Иймээс хууль батлагдсанаар улсын төсөвт хүндрэл учрахгүй.

Түүнчлэн, конвенциор хүлээх үүргээ хэрэгжүүлэхэд олон улсын хамтын ажиллагаанд түшиглэх боломжтой.

## **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль 1993 онд батлагдсан бөгөөд хамгийн сүүлд 2003 онд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Энэхүү хуулийн зарим зүйл заалт нь агуулга, зарчим, нэр томъёоны хувьд шинэчлэгдэн батлагдсан УИХ-ын сонгуулийн хууль, Орон нутгийн сонгуулийн хуультай нийцэхгүй байгаа тул уг хуулийн зарим зүйл заалтыг дээрх хуулиудтай уялдуулах зорилгоор нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүнд:

Уг хуулинд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгааг нарийвчлан тогтоож улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгалаа. Түүнчлэн талархан дэмжигч нам, байгууллага, иргэд сонгуульд зориулж мөнгөн бус хандив өргөвөл түүнийг мөнгөн хэлбэрт шилжүүлэн үнэлж, хандивын дээд хэмжээний дүнд оруулан тооцохоор мөн тусгалаа.

Хууль зөрчсөн тохиолдолд торгох шийтгэлийн хэмжээ нь 4000-250 000 төгрөг байсныг УИХ-ын сонгуулийн хуульд нийцүүлэн 150 000- 1 000 000 төгрөг хүртэл хэмжээтэй болгож шийтгэл хүлээлгэх үндэслэлүүдийг нарийвчлан тодорхойлсон.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн санал хураах өдрийг сонгуулийн жилийн тавдугаар сарын сүүлийн хагасын ням гаригт байхаар тусгасан.

Сонгуулийн бүх шатны хороодын бүрэлдэхүүн, хороодын үйл ажиллагаандаа мөрдөх зарчмыг шинэчлэн тогтоов. Тухайлбал:

- Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нэг намын гишүүн байхыг хориглох,

- Сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд улс төрийн албан тушаалтныг оруулахыг хориглох,
- УИХ-аас баталсан Сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрмийг баримтлан ажиллана.
- Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нэр дэвшигчийн талаар сурталчилгаа хийхийг хориглоно

Мөн сонгуулийн нутаг дэвсгэрийн хороог байгуулахдаа тухайн хэсгийн хорооны бүрэлдэхүүний тоог сонгогчын тоо, ажлын хэмжээг харгалзан тухайн хэсэгт

2000 хүртэл сонгогчтой бол 9 эсвэл 11

2001-4000 хүртэл сонгогчтой бол 11 эсвэл 13

4001-6000 хүртэл сонгогчтой бол 13 эсвэл 15 байхаар тусгасан.

Сонгогчын нэрсийн жагсаалт үйлдэх, танилцуулах, нэр дэвшүүлэх, сонгуулийн өмнөх ухуулга сурталчилгаа зохион байгуулах, санал хураах ажлыг зохион байгуулах, ажиглагчийн эрх үүрэг, саналын хуудас тоолох, санал хураалтын дүн гаргах журамд зарим зохицуулалтыг нэмж оруулан өөрчилсөн.

Мөн сонгуулийн ухуулга сурталчилгааг Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх радио, телевизээр явуулж болохоор тусгасан.

## **АХМАД НАСТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

2008 оны 7 сарын 1-ээс “Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавъяат цолтон, ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай” хууль хэрэгжиж Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын цолтон ахмад настанд сар бүр 200.000 төгрөг, гавъяат цолтон ахмад настанд сар бүр 150.000 төгрөгийн нэмэгдэл олгож байгаа билээ. Гэтэл Монгол Улсын тусгаар тогтнолын төлөө амь биеэ хайрлалгүй тэмцэж явсан ахмад дайчдад улиралд нэг удаа 50.000 төгрөг буюу жилд 200.000 төгрөг олгож байгаа нь дээрх алдар цолтой ахмад настнуудтай харьцуулахад 5-6 дахин бага байна. Иймд Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулж дайнд оролцсон ахмад настнуудын нийгмийн халамжын талаар анхаарах нь зайлшгүй шаардлагатай болсон. Ахмад дайчид нь Монгол Улсын тусгаар тогтнолын төлөө ихээхэн үүрэг гүйцэтгэсэн гавъяатай хүмүүс . Эдгээр ахмадуудад улирал бүр нэг удаа олгож байсан мөнгөн тусламжыг сар бүр олгохоор хуульд өөрчлөлт оруулсан. Улсын хэмжээнд 1816 ахмад дайчин одоо амьд сэрүүн байгаа. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулиар ахмад дайчдад улиралд нэг удаа 50 000 төгрөгийн мөнгөн тусламжийг олгож байсныг сар бүр 200.000 төгрөгийн мөнгөн тусламж болгон нэмэгдүүллээ.

## **ХОЁР. УИХ-ЫН 2009 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН**

Дэлхий нийтийн санхүү, эдийн засгийн хямрал болон дотоодын хүчин зүйлийн улмаас Монгол улсын эдийн засагт гарсан бууралтыг цаг алдалгүй зогсоож хямралаас үүдэн гарах санхүү, эдийн засгийн хүндрэл, бэрхшээлийг даван туулах арга хэмжээг цаг алдалгүй авах үүднээс Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан хууль, тогтоолын төслийг яаравчлан хэлэлцэх зорилгоор Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг зарлан хуралдууллаа.

Улсын Их Хурлын 2009 оны ээлжит бус чуулганаар нийт 18 хууль, 7 тогтоол баталсан. Үүний дотор Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөл, Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль,

УИХ дахь Ардчилсан намын бүлэг 8 удаа хуралдаж нийт 10 асуудал хэлэлцэн холбогдох санал, дүгнэлтийг гаргалаа.

### **2009 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНААР БАТЛАГДСАН ХУУЛЬ, УИХ-ЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**

#### ***Бие даасан хууль:***

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ /2009.02.13/

#### ***Нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль:***

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2009.02.13/

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2009.02.13/

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2009.02.13/

Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2009.02.13/

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2009.02.20/

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2009.02.20/

Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд нэмэлт оруулах тухай /2009.03.06/

Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2009.03.12/

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2009.03.12/

Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай /2009.03.12/

Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2009.3.12/

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай /2009.03.12/

Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2009.03.13/

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2009.03.13/

Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2009.03.13/

**Гэрээ, конвенци соёрхон баталсан хууль:**

Ноот бичиг соёрхон батлах тухай /2009.03.03/

**Хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль:**

Хууль хүчингүй болсонд тооцох тухай /Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай/ /2009.02.13/

**УИХ-ын тогтоол:**

Хуулийн төсөл буцаах тухай /2009.02.13 №21/ / Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл/

Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай /2009.03.03 №22/

Тогтоолын төсөл буцаах тухай /2009.03.06 №23/ /"Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг бууруулан мөрдөх тухай", "Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг бууруулан мөрдөх тухай", "Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг бууруулан мөрдөх тухай", "Зарим албан тушаалын цалингийн хэмжээг бууруулан мөрдөх тухай"/

Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай /2009.03.12 №24/

Хуулийн төсөл буцаах тухай /2009.03.12 №25/ /Гаалийн тарифийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд/

1999 оны 27 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай /2009.03.12 №26/

Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай /2009.03.13 №27/

**МОНГОЛ УЛСЫН 2009 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Улсын Их Хурлын 2009 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн нэгдсэн чуулганаар Монгол Улсын 2009 оны төсвийн тухай, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуулиудыг баталлаа.

Улсын Их Хурлын даргын захирамжаар уг хуулийн төсөл дээр ажлын хэсэг байгуулж ажилласан бөгөөд тус ажлын хэсэг нь намын бүлгүүд, гишүүдийн гаргасан саналыг харгалзан цалингаас бусад төсвийн зарлагыг 300,0 орчим тэрбум төгрөгөөр хорогдуулах, зарим татварын орлогыг нэмэгдүүлэх замаар төсвийн ачааллыг багасгаж нэмэгдэл эх үүсвэрийг бий болгох талаар нэмэлт тооцоо судалгаа хийж шаардлагагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 2009 онд хойшлуулах, төсвийн байгууллагуудын захиргааны зардлыг 20-50 хувиар бууруулах чиглэлээр санал боловсруулсаныг УИХ-аар хэлэлцэн батласан.

Төсвийн байгууллагын ажиллагсадын цалингийн хэмжээг бууруулах Засгийн газрын саналыг дэмжээгүйгээс гадна багш нарт олгох урамшууллыг хэвээр олгох шийдвэрлэсэн болно.

Монгол Улсын 2009 оны төсвийн жилд төвлөрүүлэх Гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх авто замын байгууламжийн хөрөнгө оруулалтын хэмжээг 2008 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 46,243.4 сая төгрөгийг 32,029,5 сая төгрөгөөр, Төсвийн орлогын хэмжээг 1,847,794.5 сая төгрөгийг 1,621,336,5 сая төгрөгөөр, Төсвийн зарлагын хэмжээг 2,200,942.8 сая төгрөгийг 1,854,741,1 сая төгрөгөөр, Их засварын зардлын хэмжээг 409,141,3 сая төгрөгийг 241,752,9 сая төгрөгөөр тус тус бууруулан баталлаа.

Мөн түүнчлэн Монгол Улсын 2009 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ 25,228.8 сая төгрөг байсныг 13,554.1 сая төгрөг болгон бууруулан баталлаа. Орон нутгийн төсвөөс улсын төсөвт татан төвлөрүүлэх орлогын хэмжээ 112,668.8 сая төгрөг байсныг 119,133.1 сая төгрөг болгон баталлаа.

Төсвийн тодотголыг хэлэлцэхдээ боловсрол, эрүүл мэндийн зардлыг бууруулахгүй байх, ажлын байр бий болгоход чиглэгдсэн бөгөөд нэгэнт эхлээд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлыг үргэлжлүүлэн дуусгах нь зүйтэй гэсэн зарчмыг Улсын Их Хурал баримтлав.

**Монгол Улсын төсвөөс 2009 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ**

| Д/д | Аймаг       | Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/ |
|-----|-------------|----------------------------------------------------|
| 1   | Архангай    | 938.5                                              |
| 2   | Баян-Өлгий  | 1,089.3                                            |
| 3   | Баянхонгор  | 1,354.4                                            |
| 4   | Говь-Алтай  | 1,117.1                                            |
| 5   | Дундговь    | 983.4                                              |
| 6   | Завхан      | 1,623.4                                            |
| 7   | Өвөрхангай  | 1,503.8                                            |
| 8   | Увс         | 1,837.1                                            |
| 9   | Ховд        | 1,108.1                                            |
| 10  | Хөвсгөл     | 1,878.8                                            |
| 11  | Говь-Сүмбэр | 119.0                                              |
|     | Нийт дүн    | 13,554.1                                           |

**Орон нутгийн төсвөөс улсын төсөвт татан төвлөрүүлэх орлогын хэмжээ**

| Д/д | Аймаг     | Татан төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/ |
|-----|-----------|--------------------------------------------------|
| 1   | Булган    | 945.7                                            |
| 2   | Дорноговь | 3,779.9                                          |

|    |             |           |
|----|-------------|-----------|
| 3  | Дорнод      | 1,162.5   |
| 4  | Өмнөговь    | 10,552.0  |
| 5  | Сүхбаатар   | 899.1     |
| 6  | Сэлэнгэ     | 6,240.1   |
| 7  | Төв         | 3,216.4   |
| 8  | Хэнтий      | 470.8     |
| 9  | Дархан-Уул  | 2,889.2   |
| 10 | Улаанбаатар | 62,751.2  |
| 11 | Орхон       | 26,226.2  |
|    | Нийт дүн    | 119,133.1 |

Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдсон Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Тэмдэгтийн хураамжийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эх хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын анхны хэлэцүүлгийг хийж Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хэлэлцэн баталсан.

Эдгээр хуулиудыг батласнаар татварыг Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр ногдуулж төлдөг болж байна.

### **САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ УИХ-ЫН ТОГТООЛ**

Улсын Их Хурлын 2009 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар Санхүү эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолыг баталлаа.

Уг тогтоолд Монголын эдийн засгийн өнөөгийн онцлог нь бусад орнууд хямралын үед сангийн тэлэх бодлогыг хэрэгжүүлж, төсвийн алдагдлаа тодорхой түвшинд нэмэгдүүлж байнга бол манай улсын хувьд анхнаас 2009 оны төсвийг 2008 оны эцсээр УИХ-аас батлахдаа төсвийн алдагдлын хэмжээг хэт их буюу ДНБ-ийн 6.1%-тай тэнцэх түвшинд тогтоосон нь төсвийн зарлагыг санхүүжүүлэхэд өнөөгийн нөхцөлд улам их хүндрэл учруулахаар болж байгаа бөгөөд 2009 онд төсвийн орлого цаашид төлөвлөсөн хэмжээнээс буурах хандлагатай байгаа тул төсвийн алдагдлын болзошгүй хэмжээ УИХ-аас баталсан хэмжээнээс давахаар байна. Иймээс төсвийн бодлогын хүрээнд хямралын эсрэг арга хэмжээний гол чиглэл нь цаашид төсвийн тэлэх бодлогыг хэрэгжүүлэх бус, төсвийн тодотголыг бодит түвшинд төлөвлөх, төсвийн зарлагыг бууруулах, үр өгөөжийг нь дээшлүүлэх, төсвийн алдагдлыг багасгахад оршиж байгаа юм. Хямралыг даван туулах Засгийн газрын төлөвлөгөөний үндсэн зорилго нь Монгол Улсын 2009 оны эдийн засгийн өсөлтийг 2.7-5%-иас бууруулахгүй байх, санхүү эдийн засгийн сөрөг үр дагавараас иргэдэд учрах хохирол, сөрөг нөлөөлөлийг багасгах, ажлын байрыг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

Төлөвлөгөөний бүтэц нь

- төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд
- мөнгөний бодлогын хүрээнд

- бодит салбарын хөгжлийг дэмжих хүрээнд
- хүн амын амьжиргааг дэмжих хүрээнд
- Улаанбаатар хотын хүрээнд гэсэн

5 үндсэн гол чиглэлийг удирдлага болгон боловсруулсан ба төлөвлөгөөг 2009 оны 2 дугаар сарын эхнээс 2009 оны 7 дугаар сарын 1 хүртэл хэрэгжүүлэхээр 2009 оны 03 дугаар сарын 03-ны өдөр ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан болно.

Уг төсөл батлагдах явцад УИХ дахь Ардчилсан намын бүлгээс гаргасан Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан “Санхүү, эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг даван туулах тухай” УИХ-ын тогтоолын төслийн танилцуулга болон санал дүгнэлт. Үүнд:

Нэг. Эдийн засгийн бодлогын хүрээнд:

Эдийн засгийн өсөлтийг дэмжих макро түвшний тогтворжилт нь мөнгөний бодлогоор дамжин хэрэгждэг тул уг төлөвлөгөөг төрөөс баримтлах мөнгөний бодлоготой нягт уялдуулах шаардлагатай байна. Үүнд дараахь асуудлуудыг тусгаж өгөх нь зүйтэй гэж үзлээ.

Дотоодын зах зээл дэх валютын ханшийг эдийн засагт дарамт болохгүй, тодорхой түвшинд тогтоон төгрөгийн ханштай уяж өгөх;

Төв банкны бодлогын хүүг одоогийн байгаа 9.74 хувиас буулган нэг хувьд хүргэх;

Мөнгөний нийлүүлэлтийг үнийн өсөлтийг хөөрөгдөхгүй байх зохистой хэмжээнд нэмэгдүүлэх;

Нийгмийн халамжийг зайлшгүй шаардлагатай нийгмийн эмзэг хэсэгт хүртээх;

Үр ашиггүй захиргааны зардлуудыг танах;

Санхүүжилт зайлшгүй шаардлагатай төсвийн хөрөнгө оруулалтыг тодорхойлох

Засгийн газар, ААН, байгууллага, иргэдийн хоорондын төлбөрийг чекээр үйлддэг БНСУ зэрэг гадаад орнуудын жишээг яаралтай судалж нэвтрүүлэх;

Иргэд, ААН-ийн хадгаламжийг төгрөгөөр байршуулж, банкин дахь төгрөгийн хадгаламжид төрөөс баталгаа гаргах;

Хоёр. Бодит салбарын хүрээнд:

- Хөрөнгө оруулалтын бодлогын асуудлыг авто зам, эрчим хүч гэх мэт бодит салбарт хандуулж, хэмжээг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх. Барилгын компаниудаас нийт 200 тэрбум төгрөгийн үнэт цаасыг Засгийн газар худалдаж авах замаар дэмжих

- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх ялангуяа мах, сүүний үйлдвэрлэлд төрөөс татаас өгч малчдын гар дээрх бодит орлогыг нэмэгдүүлэх, ХАА-н салбарт ажиллагсдад бүтээгдэхүүнээр хорших хэлбэрийг урамшуулан дэмжих

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан суурин газар бүрт 200 га газарт чацаргана тариалах, барилгын салбар, авто замын төсөл дээр өөрийн орны иргэдээ ажиллуулах зэргээр ажлын байр нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

Хөрөнгийн зээл олгох замаар алт олборлолтын хэмжээг 2 дахин нэмэгдүүлж жилд 40 тн хүргэх ингэснээр 1.2 тэрбум ам.долларын нэмэлт валютын эх үүсвэр олох боломжтой гэж үзэж байна. Алт олборлогч ААН-үүд олборлосон алтаа арилжааны банкинд бус зөвхөн Монголбанкинд тушаадаг болгох арга механизмыг бий болгох нь валютын хомсдолоос гарах нэг гарц болно. Түүнчлэн Бороо гоулдын олборлосон алтыг Монголбанкинд тушаах арга хэмжээг яаралтай авах;

- Нүүрс экспортлогч ААН, байгууллагуудад ч мөн адил импортоор орсон орлогоо гадагшаа бус эргэж дотооддоо оруулж ирэх нөхцлөөр эргэлтийн хөрөнгийн зээл олгох замаар санхүүгийн хөшүүрэг, татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх;

- Аймаг бүрт алтны шороон ордыг төрийн зохицуулалт, хяналттайгаар байгаль орчинд халгүй хэлбэрээр иргэддээ хуваарилж алтны олборлолт хийлгэх замаар ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх;
- Экспортыг нэмэгдүүлэх зорилгоор өөрийн бүтээгдхүүнээ экспортолж байгаа ААН, байгууллагыг гаалийн болон бусад боломжтой хэлбэрийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх замаар дэмжлэг үзүүлэх;
- Импортыг багасгах зорилгоор дотоодын хэрэгцээг үндэсний үйлдвэрлэлээр хангах чиглэлийг баримтлах, импортыг орлох үйлдвэрлэл явуулж байгаа ААН-дийг татварын бодлогоор дэмжих;

Гурав. Эрхзүйн орчны хувьд:

Засгийн газар зөвхөн гадаад эх үүсвэрээс бус дотоод эх үүсвэр, нөөц бололцоонд тулгуурласан, гадаад эх үүсвэрийг нэмэлт хувилбарыг тусгасан төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай байна. Үүнтэй уялдуулан төсвийн тодотголыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2009 оны төсөв, Үндсэн чиглэл дэх үр ашгаа шууд буюу богино хугацаанд өгөх, цаашид санхүүжилтийн эх үүсвэр болохуйц хөрөнгө оруулалтаас бусад төслийг танасан, төсвийн нийт зарлагын хүрээнд арвилан хэмнэх үүднээс шүүмжлэлтэй хандаж нягт нямбай боловсруулан УИХ-аар ойрын хугацаанд өргөн барьж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Ажлын байрыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт хийх боломжийг нээх замаар иргэдийг орлоготой болгох, ядуурлыг бууруулах зорилгоор татварын багц хуулиудад дараах нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах шаардлагатай байна.

- ААНОАТатварын тухай хуульд ажлын байр шинээр бий болгосон, цомхотгол хийхгүйгээр ажлын байрыг хадгалж байгаа ААН-дэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;
- НӨАТатварын тухай хуульд салбарын бодлоготой уялдуулан НӨАТатвараас хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, тухайн салбарт хувь хэмжээг нь ялгавартай тогтоох;
- Эдийн засаг долларжиж байгаатай уялдан төрийн байгууллага, ААН, иргэд хоорондын бүх хэлбэрийн төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг болон чекээр хийдэг болох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх
- Зарим бүтээгдхүүний үнийн өсөлтийн албан татварыг алтны хувьд хүчингүй болгох
- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн болон холбогдох бусад хуулиудад шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах замаар УИХ, Засгийн газрын хийх ажлыг зааглаж, шаардлагатай үед Засгийн газар түргэн шуурхай арга хэмжээ авах бололцоогоор хангаж өгөх зэрэг хууль эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай байна гэж үзэж байна.

Дөрөв. Нийгмийн халамжийн бодлогын хүрээнд:

- Нийгмийн халамжийн салбарт явуулж байгаа бодлогыг эргэн харж халамжийг нийгмийн эмзэг хэсэгт оновчтой хүргэх

Тав. Олон нийтэд хандсан бодлогын хүрээнд:

Засгийн газар эдийн засаг, төсөв санхүүгийн нөхцөл байдал болон санхүү, эдийн засгийн хүндрэлээс гарах боломж, хямралын эсрэг хийгдэх ажлууд, түүнд холбогдох хөтөлбөр төлөвлөгөө, түүний давуу талыг ард иргэд, олон нийтэд үнэн зөв мэдээлэх замаар нийгмийн бүх түвшинд санхүү, эдийн засгийн хүндрэлтэй тэмцэх хамтын ажиллагааг идэвхжүүлэх шаардлагатай байна.

Эцэст нь тогтоолын төслийн агуулгад зохицсон оновчтой нэр томъёог хэрэглэх (Улс орны санхүү, эдийн засгийг идэвхжүүлэх төлөвлөгөө) нь зүйтэй гэж үзэж байна.

## **ОЮУ ТОЛГОЙ ОРДЫГ АШИГЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг батлах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газраас 2009 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл нь 4 хавсралт, оршил болон 16 бүлэг, 172 хэсэг, давхардсан тоогоор 273 заалттай. Төсөлд нийт 7 төрлийн албан татварыг хууль тогтоомж шинээр батлагдсанаас үл хамааран Хөрөнгө оруулах гэрээг байгуулах үед мөрдөж байсан үеийн хуульд заасан хувь хэмжээгээр Хөрөнгө оруулагч тогтвортой төлөхөөр тусгасан. Татварын ерөнхий хуулийн 3.1 дэх хэсэгт Татварыг зөвхөн УИХ хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй гэж заасан бөгөөд гэрээний төсөлд зарим албан татварын хувь хэмжээ, тооцох аргачилалыг хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд зааснаас өөрөөр тогтоосон байна. Тухайлбал, Хөрөнгө оруулагч нь зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн дагуу албан татвар төлөх үүрэг хүлээхгүй бөгөөд, харин Нөөцийн ашгийн нэмэлт төлбөр /шинэ төрлийн татварын төрөл/-ийг төлөхөөр гэрээний төсөлд тусгасан байна. Мөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Гаалийн тухай хууль зэргээс өөр журам тогтоосон заалтуудыг ч энэхүү гэрээний төсөлд тусгасан байгаа болно.

Энэхүү гэрээ болон холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэх эсэх асуудлыг УИХ дахь Ардчилсан намын бүлэг 2009.03.09-2009.03.11 өдрийн 3 удаагийн бүлгийн хурлаар авч хэлэлцэн “Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй. Тэгэхдээ Ашигт малтмалын тухай хуулийн 30.1.1-д заасны дагуу хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахдаа эхний 5 жилд оруулах хөрөнгий хэмжээ, хугацаа, үйлдвэрийн хүчин чадал, бүтээгдэхүүний нэр төрөл, орд ашиглах арга, технологийн талаархи мэдээлэл, техник, эдийн засгийн үндэслэлийг бүрэн ирүүлсэний дараа холбогдох Байнгын хороогоор үргэлжлүүлэн хэлэлцэх нь зүйтэй” гэж шийдвэрлэсэн.

Энэхүү хэлэлцүүлгийн явцад УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүдээс гэрээний талууд, татварын нөхцөлүүд, УИХ-ын даргын 40 дүгээр тогтоолын биелэлт, байгаль орчин, техник эдийн засгийн үндэслэл, гэрээний хугацаа, эцсийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн хүчин чадлын хэмжээ, дэд бүтэц гэх мэтийн маш олон төрлийн асуудал дээр тодорхой санал, шүүмж гаргаж байсан бөгөөд энэхүү санал, шүүмжийг тусгасан саналыг холбогдох байнгын хороодод хүргүүлэхэд бэлдэж байна.

Мөн Эдийн засгийн Байнгын хорооны 21 дүгээр тогтоолоор байгуулагдсан Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэх хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт тодорхой тооны гишүүд орж ажиллаж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 30.1.1-д заасан материалууд болон холбогдох судалгааг ирүүлсэний дараагаар энэхүү гэрээг маш нарийн судлах шаардагатай байгаа тул УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцэх боллоо.

## **ИРГЭДИЙН ЗОРЧИХ НӨХЦӨЛИЙГ ХАРИЛЦАН ХӨНГӨВЧЛӨХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ БОЛОН БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ГАДААД ХЭРЭГ, ХУДАЛДААНЫ ЯАМ ХООРОНД СОЛИЛЦСОН НООТ БИЧГИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

Монгол Улсын Засгийн газраас 2009 оны 02 дугаар сарын 13-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Иргэдийн зорчих нөхцөлийг харилцан хөнгөвчлөх тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам болон Бүгд Найрамдах Солонгол Улсын Гадаад хэрэг, худалдааны яам хооронд солилцсон Ноот бичиг нь “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 16.1, 26.1 дахь заалт болон Засгийн газрын 2003 оны 168 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг бүртгэх, гадаадын иргэн Монгол Улсад түр болон удаан хугацаагаар оршин суух, байнга оршин суух, цагаачлах журам”-ын 2.1-т заасны дагуу түр ирэгч гадаадын иргэнийг 7 хоногийн дотор Гадаадын иргэн харъяатын асуудал эрхлэх албанд бүртгүүлэх заалттай нийцэхгүй байсан буюу холбогдох хууль, тогтоомжид зааснаас өөр журам тогтоох болж ааёйгай тул энэхүү Ноот бичгийг УИХ-аар соёрхон батлуулах тухай хуулийн төслийг Засгийн газраас өргөн мэдүүлсэн юм.

Үүний дагуу УИХ-ын бүтэцийн байгууллага болох УИХ дахь Ардчилсан намын бүлэг нь энэхүү Ноот бичгийг батлах нь зүйтэй, нэмж бусад орнуудтай ийм төрлийн Ноот бичиг солилцох бололцоо байгаа эсэхийг судлах нь зүйтэй гэсэн байр суурьтай байсан.

Энэхүү Ноот бичиг нь Давхардсан тоогоор жилд манай 36 мянга гаруй иргэн Монголоос БНСУ-д, Солонгосын 44 мянга гаруй иргэн манай улсад тус тус зорчиж байгааг харгалзан Хоёр тал энгийн паспорттай иргэдэд нэг удаагийн орох-гарах визийг 30 хоног байсныг 90 хоногийн хугацаатай олгох, Хоёр тал 90 хоногийн визтэй зорчиж буй иргэдийг гадаадын иргэдийн бүртгэлээс харилцан чөлөөлөх, Дээрх ангиллын визтэй нэг улсын иргэн паспортаа гээгдүүлсэн тохиолдолд буцах үнэмлэхээр хил нэвтрүүлэх зэрэг гол заалтуудаас бүрдсэн Ноот бичиг байсан. Ноот бичиг батлах ач холбогдол нь дээрхи үндсэн заалтуудаас гадна тодорхой хугацааны дараагаар харилцан визгүй зорчих урьдчилсан нөхцөл болж байгаагаараа ихээхэн ач холбогдолтой юм.

Энэхүү Ноот бичгийг Монгол Улсын Их Хурал 2009 оны 03 дугаар сарын 03-ны өдөр соёрхон баталсан болно.

## **ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН 2009 ОНЫ 01 ТООТ ДҮГНЭЛТ**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2009 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн дунд суудлын хуралдаанаараа баг, хорооны Засаг даргыг улс төрийн албан тушаалын ангилалаас хасч Төрийн захиргааны албан тушаалын ангилалд оруулан Төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг томилуулах санал оруулахаар хуульчилсан Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох хэд хэдэн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцээд дүгнэлт гаргажээ.

Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх, томилох

журмыг нэг адил зарчмаар хуульчилсан байтал Улсын Их Хурал Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн заалтаар баг, хорооны Засаг даргыг улс төрийн албан тушаалын ангиллаас хасч, Төрийн захиргааны албан тушаалын ангилалд оруулан төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг баг, хорооны Засаг даргад нэр дэвшүүлж, томилуулах санал оруулахаар нэмэлт, өөрчлөлт оруулан хуульчилсан нь Монгол улсын үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тухайн иргэдийн Нийтийн Хурлын баг, хорооны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, харьяалах сум, дүүргийн Засаг даргын баг, хорооны Засаг даргыг томилох бүрэн эрхийг явцууруулан хөндлөнгөөс оролцох боломжийг бүрдүүлсэн байна гэж үзжээ.

Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12-ыг "баг, хорооны Засаг дарга" гэсэн заалт, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн "...төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Засаг даргыг тухайн ...баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, ...баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно", Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно..." гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн дүгнэлтийг гаргаж, Төрийн албаны тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн дээрх заалтуудын үйлчилгээг 2009 оны 3 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлэхээр шийдвэрлэжээ.

Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороод УИХ дахь Ардчилсан намын бүлэг Үндсэн хуулийн Цэцийн 2009 оны 01 дүгнэлтийг авч хэлэлцээд дэмжих саналтай байгаа гэдгээ илэрхийлсэн бөгөөд УИХ-ын ээлжит бус чуулганы 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэж дээрхи дүгнэлтийг хүлээн авахаар шийдвэрлэв.

## **БАНКИН ДАХЬ МӨНГӨН ХАДГАЛАМЖИД БАТАЛГАА ГАРГАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

УИХ-ын 2009 оны намрын ээлжит бус чуулганы 3 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж, Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан саналын дагуу уг хуулийг анхны хэлэлцүүлгээр нь батлав.

Төрөөс байгууллага, иргэдийн харилцах дансны үлдэгдэлд баталгаа гаргаж байгаа нь бүх хариуцлагыг төр хүлээж, арилжааны банкуудад итгэх иргэдийн сонирхлыг нэмэгдүүлэхэд оршино.

Төрөөс гаргаж байгаа баталгаанд тухайн банкинд хугацаа хэтэрсэн зээл, түүнтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын өр төлбөртэй этгээд, түүнтэй нэгдмэл сонирхолтой бусад этгээдийн мөнгөн хадгаламж, харилцах дансны үлдэгдэл, банк хоорондын захаас татан төвлөрүүлсэн мөнгөн хадгаламж, харилцах дансны үлдэгдэл, эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр нотлогдсон этгээдийн өөрийн болон бусдын нэр дээр байршуулсан мөнгөн хадгаламжийг төрийн баталгаанд хамруулахгүй байх нь зүйтэй гэж үзжээ.

## **НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ БОЛОН АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИУДАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиудын эцсийн найруулгыг УИХ-д танилцуулсны дараа агуулга, бодлого, зарчмын болон найруулга, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн чанартай олон засвар хийснээрээ УИХ-ын дарга Ц.Нямдорж Үндсэн Хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн гэж дүгнэсэн. Үндсэн Хуулийн цэцийн 2007 оны 06 дугаар дүгнэлттэй холбогдуулан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиудад өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-ын ээлжит бус чуулганы 2009 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэж батлав.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 132 хэсэг, заалтад засвар хийгдсэнээс найруулгын засвараас хэтэрсэн байж болох 6 засвар, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 101 хэсэг, заалтад засвар хийгдсэнээс найруулгын засвараас хэтэрсэн байж болох 4 засварыг дээрхи хуулиудын эцсийн найруулгад байсан хэлбэрээр нь буцаан суулгахаар боллоо.